

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**

Өдөр +30  
Шөнө +18

**УЛС ТӨР**

Д.БАТТУЛГА: МАН-ЫНХАН БОЛОМЖОО ЭДЭЛЖ ЧАДСАНГҮЙ

IV нүүрт

**ОНИЦЛОХ ХУУДАС**

УСАНД ОСОЛДОХ НЬ ИХЭСЧЭЭ

V нүүрт

Дугаарын **60** мөр

Төрийн албаныхан ажлаа хийхээ больжээ

Н.ПУНЦАГБОЛД

УИХ-ын ээлжит сонгууль дуусч, ард түмэн сонголтоо хийгээд байгаа билээ. Энэ удаагийн сонгуулийн үр дүнгээр МАН үнэмлэхүй ялалт байгуулж, дангаар засаг барихаар болоод байгаа. Нийслэлд хүртэл МАН ялсан. Өнгөрсөн дөрвөн жилд засаг барьсан АН-ын хувьд гэнэтийн цохилт болж, ард түмэн санаанд оромгүй сонголт хийчихээд байгаа билээ. Тэгвэл сонгуулийн үр дүн гарсны маргаашнаас эхлээд л төрийн албан хаагчид “ажил хаялт” зарлаж эхэллээ. Сонгууль дууссанаас хойш төрийн албанд ажиллаж байгаа албан хаагчид бараг л ажил хийсэнгүй. Учир нь даваа гарагийн өглөө төрийн албан хаагчид бүгдээрээ ажлаа хүлээлгэж өг гэсэн утга бүхий “зарлиг”-ийг эрх барих эрхээ авсан МАН-ынхан буулгасан талаар явган яриа явав.

Үргэлжлэл нь III нүүрт

## ХҮН ЦАРЦААНУУД ТӨРД ТЭРСЭЛСЭН ГЭМТ ХЭРЭГТНҮҮД БУС УУ



**Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**

Хүн “царцааны нүүдэл” бол төрийн эсрэг зохион байгуулалттайгаар өдүүлж буй гэмт хэрэг мөн. Бүр зохион байгуулалттайгаар шүү. Чингисийн үед төрийнхөө эсрэг гэмт хэрэг үйлдэх бүү хэл санаа агуулсан бол тэр дор нь үг дуугүй цаазалдаг

байв. Харин эдүгээ төрийнхөө эсрэг гэмт хэрэгт хэдэн арван мянгаараа нэгдсэн иргэдэд ямар шийтгэл ногдуулах ёстойг бүх ард түмнээрээ хэлэлцвэл зохино. Монгол төрийн босго дэндүү намхан болжээ. Босго нь намхан гэрийн хойморт хулгана, зурам гүйдлэн авдар дээр залсан бурхны өмнө идээг зуугаад хүний хөлийн

чимээнээр ханын нүдээр гарч зугтах юу ч биш. Түүнтэй ижил бор халзан хонь байтугайд нь төрийн өндөр дээд босго намдаж, ээтэн гутлынхаа хоншоорыг өргөх шаардлага гарсангүй. Тэгэхээр манай улсад төр гэж байна уу. Үгүй л бололтой.

Үргэлжлэл нь III нүүрт

**ОНИЦЛОХ УЛС ТӨР**

## 3.ЭНХБОЛД: МОНГОЛЫН ТӨР ХУУЛИЙН ДАГУУ БАЙГУУЛАГДАХ ЁСТОЙ

Ж.ОТГОН

АН-ын дарга 3.Энхболд болон нэр бүхий гишүүд Төрийн ордонд УИХ-ын даргын өрөөний үүдэнд мэдэгдэл хийлээ. Тэд УИХ-ын сонгуулийн дүнг зарим дүүрэг, хэсгийн хороодод хүлээн зөвшөөрөх боломжгүй учраас өнөөдөр чуулган хуралдуулах нь хууль бус гэж үзэж байгаа аж. Энэ талаар УИХ-ын дарга 3.Энхболд “Маргааш /өнөөдөр/ анхдугаар чуулган зарлагдсан байгаа. УИХ-ын тухай хуульд заасны дагуу анхдугаар чуулганыг зарлахдаа Ерөнхийлөгч УИХ-ын сонгуульд суудал авсан намуудтай зөвшилцөх ёстой. Тэгвэл зөвшилцөх ажил хийгдээгүй байгаа. Тиймээс маргааш анхдугаар чуулганыг хийх нь зохимжгүй байна. Учир нь дөрвөн төрлийн зөрчлийг нягтлах хэрэгтэй байна. Энэ дагуу Цэцэд өргөдөл өгөөд байгаа. Ер нь сонгуулийн бүх ажил хуулийн дагуу явагдах учиртай. Зөрчлүүдийн хувьд нэгдүгээрт, долоо хоногийн өмнө бидний өгсөн “60 тэрбум төгрөгөөр төрийн албыг зараад, тэр мөнгөөрөө сонгуульдаа орох” тухай МАН-ын дарга М.Энхболд, нийслэлийн МАН-ын хорооны дарга Ц.Сандуй нарын бичлэгийг хуулийн байгууллага ямар нэгэн шалгах ажиллагаа явуулсангүй. Тиймээс үүнийг тодруулж, хуулийн байгууллагууд харилцаа гаргах хэрэгтэй. Яагаад гэвэл энэ сонгуультай шууд холбогдож байгаа асуудал. Хоёрдугаарт, саналын хуудас, хар машины тоо зөрсөн асуудал гарлаа. Тухайлбал, Хан-Уул дүүргийн 55 дугаар тойрогт гэхэд л саналын хайрцагнаас гарсан буюу гарын үсэг зарж авсан саналын хуудасны тооноос саналын хайрцагнаас гарсан хуудасны тоо 234-өөр нэмэгдсэн.

Үргэлжлэл нь II нүүрт

**АСЕМ-11**

## АЗИ, ЕВРОП ТҮМНИЙ ХИ ЧУУЛГАН БОЛЖ БАЙНА

Ж.МЯГМАР

Улаанбаатар хотноо энэ сарын 13-14-ний өдрүүдэд АСЕМ-ийн дээд хэмжээний XI чуулга уулзалт болно. Тэгвэл АСЕМ-ийн дагалдах хурлуудын нэг Ази, Европ түмний XI чуулган өчигдөр Төрийн ордны их танхимд эхэллээ. Уг чуулган энэ сарын 4-6-ны өдрүүдэд болох юм. “Шударга, тэгш хүртээмжтэй хөгжлийн арга замыг Ази, Европт хэрэгжүүлэн, эв санааны шинэ нэгдлийг байгуулах нь” сэдвийн хүрээнд өрнөж байгаа энэхүү чуулганд АСЕМ-ын 51 орон, хоёр олон улсын байгууллагын

500 гаруй төлөөлөгч оролцож байгаа юм. Чуулганы нээлтэд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж оролцож үг хэлсэн юм. Тэрбээр “Монгол Улсын хувьд ард түмний чуулга уулзалт маш чухал юм. Манай улсын хувьд иргэдийн оролцоо нийгмийн хөгжилд асар өндөр чухал үүрэгтэй байдаг. Иргэдийн оролцоог олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллага гэж манайд нэрлэдэг. Энэ төрийн бус байгууллагаар дамжиж Монгол Улсад иргэдийн оролцоо хэрэгждэг.

Үргэлжлэл нь III нүүрт

**ДОТОР НҮҮРТ**



ИРАКТ ГАШУУДАЛ ЗАРЛАЛАА

8

# МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

## Манай сонины III улирлын захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

### Захиалгын үнэ 15400

Монгол шуудан: 70078977  
УБ шуудан: 70127027  
Скай пост: 70121294  
Түгээмэл шуудан: 70115025

**ОНИЦЛОХ МЭДЭЭ**

## Ардчилсан Ерөнхийлөгчтэйгээ АН-ынхан албан бичгээр уулзав

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Парламентад шинээр суудал авсан намуудын удирдлага, төлөөлөлүүдтэй өчигдөр Төрийн ордонд хаалттай уулзалт хийлээ. Эх сурвалжийн хэлж буйгаар АН-ынхан энэ уулзалтыг санаачилсан бөгөөд ардчилсан Ерөнхийлөгчтэйгээ уулзахын тулд тэд өөрсдөө албан бичиг үйлдэж зөвшөөрөл авсан аж. Ардчилсан намаас Ерөнхийлөгчөөр суусан Төрийн тэргүүндээ анх удаагаа намынх нь удирдлагууд албан бичиг өгч уулзсан гэх бор шувуу Төрийн ордонд дуулдаж байна. Хуралдаанаар юу яригдсан нь тодорхой бус байгаа ч ээлжит сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөх тухай, хууль бус үйлдлүүдийг хүлээн зөвшөөрөхгүй гэж мэдэгдсэн АН-ын мэдэгдлийн тухай энэ уулзалтаар хэлэлцэж, зөвшилцөлд хүрсэн гэх мэдээлэл байгаа юм. Тодруулбал, АН-ын дарга өчигдөр мэдэгдэл хийж Ерөнхийлөгч анхдугаар чуулганы тов зарлахдаа УИХ-д суудалтай нам эвслүүдтэй зөвшилцөөгүй.

Мөн МАН-ынхан хууль бусаар төрийн эрхийг авсан байх ноцтой баримт, зөрчил эхнээсээ илэрч эхэлсэн учраас хууль хяналтын байгууллага шалгаж тогтоох хүртэл УИХ-ын гишүүний тангараг өргөх нь зохимжгүй асуудал хэмээн мэдэгдсэн. Мөн эх сурвалжийн мэдээлснээр хуралдааны эхэнд Хотын захирагч Э.Бат-Үүлтэй ч ганцаархнаа уулзаж, НИТХ-ын сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрөх тухай чиглэл өгсөн гэх мэдээлэл байгаа. Хэрвээ Ерөнхийлөгч улс төрийн намуудтай зөвшилцөлд хүрч ойлголцсон бол өнөөдөр анхдугаар чуулган хуралдах учиртай. АН-ын мэдэгдлийн дараа МАН-ынхан бүлгийн хурлаа хийдэг Жанжин Д.Сүхбаатарын танхимын урд мэдээлэл хийхээр болсон ч Ерөнхийлөгчийн уулзалтын дараа цуцалсан билээ. Мөн Хуульзүйн байнгын хороог ч энэ уулзалтаас үүдэж цуцалсан гэх мэдээлэл гарсан юм. Үүнээс харахад намууд ойлголцлолд хүрсэн байх магадлал өндөр байгаа юм.

ХААН банк				Хуудалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	1983.00	1998.00	ФУНТ	2592.00	2716.00	АМ.ДОЛЛАР	1987.00	2004.00
ЕВРО	2186.00	2276.00	РУБЛЬ	28.90	33.40	ЕВРО	2188.00	2262.00
ИЕН	19.09	19.91	ЮАНЬ	296.60	303.50	ИЕН	19.12	19.82
						ФУНТ	2609.00	2699.00
						РУБЛЬ	30.10	33.30
						ЮАНЬ	297.30	303.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

# УЛС ТӨР

ОНЦЛОХ УЛС ТӨР

## 3.ЭНХБОЛД: МОНГОЛЫН ТӨР ХУУЛИЙН ДАГУУ БАЙГУУЛАГДАХ ЁСТОЙ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Өөрөөр хэлбэл, сонгогчид санал өгөөгүй хуудас хар машин руу орсон байна гэсэн үг. Энэ зөвхөн нэг тойргийн асуудал юм. Энэ асуудлыг 76 тойргоор нягталж, шалгахгүйгээр анхдугаар чуулган хийх нь хууль зөрчих юм байна.

Гуравдугаарт, зарим газарт саналын хуудас дууссантай холбоотой асуудал. Саналын хуудсыг хувилж болдоггүй. Учир нь тусгай цаасаар хийдэг. Гэтэл дууссан саналын хуудастай аймгууд буюу Баян-Өлгий, Баянхонгор, Хэнтий ээрэг аймгуудад канондсон саналын хуудсаар санал авсан байгаа юм. Энэ нь Сонгуулийн хуулийн 84.1, 99.3, 84.10, 84.14 зэрэг заалтуудыг зөрчсөн. Тиймээс канондсон саналын хуудсуудыг хасч тооцох ёстой. Энэ нь сонгуулийн дүнд нөлөөлж байгаа.

Дөрөвдүгээрт, "Царцааны нүүдэл"-ийн асуудал байна. 18 мянган "царцаа" буюу сонгогч нэг газраас хасагдаж, нөгөө газарт нэмэгдсэн. Тухайлбал, Баянхонгор, Хөвсгөл, Увс гээд олон аймагт нэмэгдсэн байна. Эдгээрсонгогчийгөөрийнбиеэр ирээгүй байхад итгэмжлэхээр сонгогчдыннэрсийнжагсаалтад бүртгүүлсэн байгаа юм. Уг нь хуульд сонгогч өөрийн биеэр ирж бүртгүүлэх ёстой. Гэтэл эдгээр сонгогчдыг 10 хоногийн өмнө бүртгүүлж, хууль зөрчсөн. Тэднийг бүртгэсэн бүртгэлийн газар хууль зөрчиж бүртгэсэн, СЕХ энэ асуудлыг хэвийн гэж үзсэн гээд сонгуулийн үеэр гарсан түм буман зөрчлийг цагдаа, шүүх нь тогтооноор байтал үл тоон 76 гишүүнийг



тангараг өргүүлэхээр оруулж байгаа нь өөрөө хэт яарсан ажил юм. Энэ сарын 29-ныг хүртэл анхдугаар чуулганыг хийх цаг хугацаа бий. Тиймээс дөрвөн асуудлыг СЕХ, Улсын бүртгэл, хуулийн байгууллагууд нягталж шалгасны дараа хэдэн хүнийг оруулах эсэхийг Ерөнхийлөгч, СЕХ шийдсэний дараа УИХ-ын гишүүний тангараг өргүүлэх хэрэгтэй. Бид шударга сонгуулийн төлөө хуулийн дагуу явсан сонгуулийн талаар хэлэх үг байхгүй. Монголын ард түмний сонголтыг хүндэтгэх болно. Гэхдээ Монголын төр хуулийн дагуу байгуулагдах ёстой. Ийм олон сонгуулийн зөрчлийн дараа тангарагаа өргөх нь зохимжгүй. Маш олон хууль зөрчихөөд УИХ-ын гишүүн болоод явна гэдэг бол тохиромжгүй байна, МАН-ын гишүүд ээ" гэлээ. Мөн тэрбээр хуулийн болоод төрийн байгууллагууд хийх ёстой ажлаа хийцгээ. Энэ сонгуулийн хуулийн онцлогийг та бүхэн мэдэж байгаа байх. Намууд сонгуулийн ажилд оролцохоо байсан. Бид зөвхөн ажиглагч хийнэ. Бусад бүх бүртгэл болоод санал тоолох, саналын хуудас хэвлэх ажлыг төрийн байгууллагууд хийдэг болсон. Тиймээс ч бид төрийн албан хаагчиддаа найдаж, энэ бүх зөрчлийг гаргахгүй байх гэж сонгуульдаа оролцсон. Гэтэл энэ мэт олон зөрчил гарлаа

хэмээлээ. Эдгээр асуудлыг шалгаж дуусахад хоёр долоо хоног хангалттай. Тиймээс энэ хугацаанд хариуцлага алдсан төрийн байгууллагууд ажлаа хийх шаардлагатайг АН-ын удирдлагууд онцолж байлаа.

*Энэ үеэр сэтгүүлчид түүнээс зарим асуултад хариулт авлаа.*

**-Наадам, АСЕМ гээд олон чухал үйл ажиллагаа болох гэж байна. Энэ хариуцлагатай үед төрийн ажлыг ингэж гацаах нь хэр нийцтэй юм бол ?**

"Төр байгуулахыг бид огт эсэргүүцээгүй. Харин хуулийн дагуу, ном журмынхаа дагуу л байгуулагдах шаардлага тавьж байна. Хамгийн аймшигтай зүйл бол ганцхан тойргийг шалгахад 234 саналын хуудас илүү тоологдож байгаа асуудал. Бид хар машинд огт эргэлзээгүй. Харин саналын хайрцагт жагаад тэдгээр хуудас илүү орсон бид гэдэгт л эргэлзэж байна. Бид АСЕМ-аас болж хуулиа зөрчиж, хууль бусаар төр байгуулж болохгүй. Тэгээд ч анхдугаар чуулганыг зөвшилцөөгүй хуралдуулах нь хууль бус.

**-Таны шаардлагыг биелүүлэхгүй анхдугаар чуулганыг хуралдуулах боломж байх уу?**

"Ер нь Үндсэн хуулийн цэц зарлигийг хүчингүй болгох

...Тийм. СЕХ-ны буруу. Учир нь бүх тойрогт 90 хувьтай нь тэнцэх саналын хуудас хэвлэж хүргүүлсэн гэж надад мэдэгдсэн. Гэтэл аль ч тойрог дээр 110 хувийн ирц гараагүй шүү дээ. Дундаж нь 70 хувь байсан. Тэгэхээр СЕХ 90 хувьдаа саналын хуудас хүргүүлээгүй болж таарч байна...

байх. Хуулийн шаардлага биелэгдээгүй байна. Тиймээс хууль бус Их хурал болно.

**-Хар машинд илүү саналын хуудсыг хэн хийх боломжтой вэ?**

"Уг нь нэг ч саналын хуудсаар зөрөх ёсгүй. Гэтэл ганцхан тойрогт 234 хуудсаар зөрж байгаа нь Улсын

бүртгэлийнхэн хийсэн ажил гэж харж байгаа. Тэд ажлаа зохих ёсоор хийсэнгүй. Тийм бохир ажил хийсэн байхад залруулах учиртай СЕХ ч ажлаа хийсэнгүй.

**-Канондсон цаасаар санал авсан нь СЕХ-ны буруу гэсэн үг үү?**

"Тийм. СЕХ-ны буруу. Учир нь бүх тойрогт 90 хувьтай нь тэнцэх саналын хуудас хэвлэж хүргүүлсэн гэж надад мэдэгдсэн. Гэтэл аль ч тойрог дээр 110 хувийн ирц гараагүй шүү дээ. Дундаж нь 70 хувь байсан. Тэгэхээр СЕХ 90 хувьдаа саналын хуудас хүргүүлээгүй болж таарч байна. Тиймээс хэдийг хүргүүлсэн эсэх гээд шалгах ажил үлдээд байна.

**-Санал авах өдөр саналын хуудас дуусчихсан гэх асуудал гарч байсан. Тухайн үед нь яагаад канондсон хуудсаар санал авч болохгүй гэдгийг хэлээгүй юм бэ?**

"Тухайн үед нь бид хэлж байсан. Бид өөр өөрсдийн тойрогтоо ажлаад завгүй байсан. Гэхдээ СЕХ-ынхон тийм зүйл хийж болохгүй гэдгээ мэдэж байгаа. Мэдэж байгаа хэрнээ л хийсэн байна.

**-СЕХ-оос канондсон хуудас биш. Нэг тойргоос нөгөөд шилжүүлсэн гээд байгаа шүү дээ?**

"Канондсон хуудсаар санал авсан гэдгийг Д.Ганбат гишүүн нотолж байна.

### БНСУ-ын Ерөнхийлөгч Монголд айлчилна

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ энэ сарын 17-18-ны өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийнэ. БНСУ-ын Ерөнхийлөгч Пак Гын Хэ-гийн албан ёсны айлчлал хоёр орны "Иж бүрэн түншлэл"-ийн харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэх, дээд, өндөр төвшний харилцан айлчлалын давтамжийг хадгалах, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх, иргэд харилцан солилцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Талууд эдийн засаг, худалдаа, мэдээллийн технологи, эрчим хүч, соёл, боловсрол, эрүүл мэнд, хөгжлийн хамтын ажиллагааны салбарт хамтран ажиллах талаар болон бүс үеэр, олон улсын харилцан сонирхсон асуудлаар санал солишно. Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Ерөнхийлөгч Пак Гын Хэ-тэй албан ёсны хэлэлцээ хийж, Ерөнхий сайд, УИХ-ын дарга нартай уулзана. Мөн Ерөнхийлөгч Пак Гын Хэ Монгол-Солонгосын бизнес форумд оролцож, манай улсад амьдрал ажиллаж буй солонгос иргэдийн төлөөлөлтэй уулзахаар төлөвлөж байгаа юм. Ерөнхийлөгч Пак Гын Хэ албан ёсны айлчлалын өмнө АСЕМ-ын дээд төвшний 11 дэх удаагийн уулзалтад оролцоно. БНСУ-ын Засгийн газар АСЕМ-ын дээд төвшний уулзалтын арга хэмжээг амжилттай зохион байгуулахад тодорхой дэмжлэг үзүүлсэн болно.

**МОНГОЛЫН МЭДЭЭ**  
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 88873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТОГТОХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АРГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Б.ӨНӨРТОГТОХ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528  
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцт эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

### ЗАСГИЙН ГАЗАР

#### Засгийн газрын ээлжит хуралдаан боллоо



Засгийн газрын ээлжит хуралдаан болж, дараах шийдвэрүүдийг гаргалаа. Тодруулбал, Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засгийн хөгжлийн хамтын ажиллагааны сангаас 2011-2018 онд авах 300 сая ам.долларын зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх "Улс, хот хоорондын нийтийн тээврийн үйлчилгээнд дэмжлэг үзүүлэх төслийн хоёр дахь шат" болон "Ухаалаг боловсрол төсөл"-ийн зээлийн хэлэлцээрүүдийн төслийг дэмжиж, эдгээр хэлэлцээрт Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж гарын үсэг зурах бүрэн эрхийг Сангийн сайд Б.Болорт олгох Ерөнхий сайдын захирамж гаргахаар тогтлоо. Мөн Бүгд Найрамдах Хорват Улс

Европын Холбооны гишүүн улс болсонтой холбогдуулан Туншлэл, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Европын холбооны хоорондын хэлэлцээрт нэмэлт оруулах тухай протоколын төслийг хэлэлцэн дэмжиж, протоколд гарын үсэг зурах эрх олгох тухай Ерөнхий сайдын захирамж гаргахаар тогтсон байна. Энэхүү протокол нь нийт таван зүйлтэй бөгөөд протокол хүчин төгөлдөр үйлчилж эхэлмэгц Европын холбооны бусад улсын адил нөхцөлөөр энэхүү хэлэлцээр Бүгд Найрамдах Хорват Улсад үйлчилж эхэлнэ. Хорват улстай тус протоколыг байгуулснаар хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг бүхий л салбарт эрчимжүүлэх, шинэ салбарт өрнүүлэх эрх зүйн суурь тавигдах юм.

#### Багануур компани Хөрөнгийн биржээр дамжуулж хувьцаа гаргалаа

"Багануур" ХК 9 сая 870 мянга 287 ширхэг хувьцааг Хөрөнгийн биржээр дамжуулан өчигдөр олон нийтэд арилжлаа. Нэмж гаргаж буй хувьцааны тоо ширхэг тус компанийн нийт хувьцааны 32 хувьтай тэнцлээ. Олон нийтэд санал болгож буй нэгж хувьцааны үнэ 2650 төгрөг юм байна. Тус компани 5000 орчим жижиг хувьцаа эзэмшигчтэй. Эдгээр

иргэд болон "Багануур" ХК-ийн хувьцааг эзэмшдэг ААН-үүд шинээр гаргасан хувьцаанаас юуны өмнө худалдан авах давуу эрхтэй. Гэхдээ тэд одоо эзэмшиж буй хувьцааны тоотой ижил хэмжээний хувьцааг л худалдан авах эрхтэй аж. 50 ширхэг хувьцаа эзэмшдэг иргэн нэмж 50 хувьцаанд л хөрөнгө оруулах боломжтой гэсэн үг юм.

Өнөөдрийг хүртэл Засгийн газар "Багануур" ХК-ийн 75 хувийг эзэмшиж, үлдсэн 25 хувийг жижиг хувьцаа эзэмшигчид эзэмшиж байв. Энэхүү 25 хувийн 21-ийг "Mongolian national coal corporation" эзэмшдэг. Түүнээс өмнө МАК энэ хувийг эзэмшиж байгаад 2013 онд АНУ-ын Firebird санд худалдан, тэднээс "Mongolian national coal corporation"-д

шилжжээ. Одоогийн хувьцаа эзэмшигчид давуу эрхээ эдлэн захиалгаа өгч дууссаны дараа үлдсэн хувьцааг нээлттэй арилжих үйл явц эхлэх юм. Нэмэлт хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа өчигдөр эхэлж, өнөөдөр дуусах өнгө. Хуульд хоёр хоног гэж заасан учраас хуулиа барьж буйг тус компанийн удирдлагууд онцоллоо. Түүнчлэн, арилжаа

дуусахад тус компани хөрөнгийн зах зээлээс 26 тэрбум төгрөг татан төвлөрүүлэх зорилготой бөгөөд энэ мөнгөөр парк шинэчлэлт хийн, хуучны тоног төхөөрөмжүүдээ шинэчлэхээр төлөвлөжээ. Хамгийн сүүлд 1990-ээд онд Японы тусламжтайгаар хөрөнгө оруулалт хийснээс дахин Багануурын уурхайд хөрөнгө оруулаагүй аж.

# ҮЗЭЛ БОДОЛ

## ХҮН ЦАРЦААНУУД

### ТӨРД ТЭРСЭЛСЭН ГЭМТ ХЭРЭГТНҮҮД БУС УУ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Төртэйсөн бол Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрхэнд зохион байгуулалттайгаар халдаж, төрийн эрхэнд халдчихаад байхад мэдсэн ч мэдээгүй царайлаад дүлий дүмбэ оргиод таг дуугүй сууж байхгүй биз. Дэлхий дахинаа Ардчилсан Монгол Улс хэмээн цэжээ дэлдсээр ирсэн ардчиллаа бид өөрсдийнхөө гараар булшилж орхилоо. Тиймээс өнөөдрөөс ардчилал гэж ам ангайсан бүхний ам руу цаас чих. Энэ УИХ-ын сонгуулиас хойш дахин сонгууль гэж бүү ам ангай. БНМАУ-ын үеийн хэн депутатаар хэнийг сонгох, хэн сонгогдох нь тодорхой байсан тэр тогтоолоо руугаа буцаад оч. Тэгээд өнөө коммунизмаа байгуул. Одоо бидэнд өөр сонголт байхгүй. Амьдралын хүрд урагшаа бус арагшаа эргээд эхэллээ. Энэ бүхэн дэндүү харамсаар үйл явдал. Харин горьц нь алс бөглүү сум, суурингийн иргэд эдэлнэ. Үнэнийг хэлэхэд, тэд өнөөдрийг хүртэл нэг намын дарлал дор аж төрчөөсөөр байсан билээ. Үүнийг гэрчлэх олон баримт өмнө минь байна. Хүүгийнхээ амьдралд дэм болохын тулд 68 настай эмгэн буурал ижий нь МАН-д хүчээр элсч, гишүүн болсныхоо буянаар өндөр настны тэтгэврийн зээл авах эрхтэй болсон амьдрал шинэ цагийн Монгол Улсад байгаа юу гэж ойлгох болж байна вэ. МАН-ын гишүүн дүү нь Ардчилсан намын гишүүн ахдаа хачраа өгөөд үнсүүдлэх эрхгүй намчирхал байна, цаана чинь. УИХ-ын сонгууль болохоор эхнэр, нөхөр хоёр нь нэгэн тоонотод багтахаа больж, сонгууль дуусахаар

нөхөр нь гэртээ харьдаг амьдрал амьдрал мөн үү. Чухам ийм утга учиргүй улстөржсөн байдлаасаа салах гэж, 26 жил ноёрхсон намаасаа ангижрах гэж ард түмэн УИХ-ын болоод орон нутгийн сонгуульд саналаа өгч, шинэ өглөө, шинэ амьдрал, шинэ төлөөллийг хүссэн юм, уг нь. Гэтэл эрх мэдэл, албан тушаалдуулайрагчид ард түмний сонгох, сонгогдох эрхэнд халдаж, монгол төрийг элгээр нь хэвтүүлэх эцсийн аргаа хэрэглэсэн нь царцааны нүүдэл гэх улс төрийн бохир арга юм. Улсын бүтгэлийн ерөнхий газраас хийсэн мэдээллээс үзэхэд, улсын хэмжээнд 18 мянган иргэн хөдөө, орон нутаг руу шилжжээ. Нэг аймагт дунджаар 3000-3800, Хөвсгөл, Увс, Баянхонгор түүнээс илүү тооны хүн царцаа санал өгсөн гэхээр хүн ам цөөтэй хоёр сумын сонгууль өгөх насны иргэдийн тооноос давж гарах жишээтэй. Хөлсний, нүүдлийн 18 мянган хүн царцаа эх орны дөрвөн зүг, найман зовхистод үлдээд мөрдөхдөө эгэл номхон ард түмнийг минь амьдаар нь, эрх, эрх чөлөөг нь уг үндэстэй нь залгив орхижээ. Хүн царцааны нүүдэл дайраад л өнгөрнө. Бус болоогүй, гол горхи, нуур шанд, далайг нь хөвч тайгатай нь бохирдуулж, архины шилээр дүүргэж

#### БАЙНГЫН ХОРОО

АН-ын удирдлагууд өчигдөр Ерөнхийлөгч хуульд заасны дагуу анхдугаар хуралдааны тов зарлах асуудлыг УИХ-д суудалтай нам эвслүүдтэй зөвшилцөхгүйгээр шийдсэн хэмээн мэдэгдэж, энэ асуудлыг Үндсэн хуулийн цэцэд шалгуулах, улмаар хууль бус зөрчил гарсан

дарга С.Бямбацогт “Төрийн албан тушаалыг наймаалцах тухай яриа бол эвлүүлэг байсан” гээд завсарлага авах хүсэлт гаргасан. Харин тус байнгын хорооны дарга Д.Ганбат “Маргаашнаас эхлээд төрийн албыг наймаалцаад эхэлбэл яах вэ. Бид хуулийн байгууллагаар шалгуулж, уг асуудалд хяналт тавих ёстой. ЦЕГ, АИТ, ТЕГ болон

## 60 тэрбумын асуудал Хуульзүйн байнгын хороог яаралтай хуралдуулахад хүргэв

учраас анхдугаар чуулганыг хойшлуулах хүсэлт гаргасан юм. Тэгвэл энэ асуудлаар өчигдөр Хуульзүйн байнгын хороо хуралдлаа. Тодруулбал, Хуульзүйн байнгын хорооны хуралдааныг 15.00 цагт зарласан ч 16.00 цаг өнгөрч эхлээ. Үүнээс өмнө МАН-ын ажлын албаны зөвлөхийн биед УИХ-ын гишүүн, Хуульзүйн байнгын хорооны дарга Д.Ганбат халдлаа гэх мэдээлэл гарсан ч энэ нь худлаа аж. Өөрөөр хэлбэл, МАН-ын бүлгийн ажлын албаны зөвлөх УИХ-ын гишүүнийг хэл амаар доромжилж, чиний цаг дууссан гэсэн утгатай зүйл хэлсэн гэх мэдээлэл байгаа юм. Юутай ч дуулиан шуугиантай эхэлсэн тус байнгын хороо 52.6 хувийн иртэй хуралдав. Ардчилсан намаас Хууль зүйн байнгын хороонд хандаж мэдэгдэл гаргасан учраас энэхүү хуралдааныг хийхээр болжээ. Тус мэдэгдэлд төрийн албан тушаалыг 60 тэрбумоор худалдсан эсэхийг шалгах, энэ асуудалд хууль хяналтын байгууллага нь анхаарах ёстойг сануулжээ. Хуралдааны эхэнд УИХ дахь МАН-ын бүлгийн

бусад байгууллагын дарга нарыг дуудаж энэ хуралдаанд суулгах хэрэгтэй. Одоо энэ танхимд хоёрхон мэргэжилтэн сууж байна. Дарга нарыг нь дуудаж ирүүлмээр байна” гэсэн юм. Энэ үеэр УИХ-ын гишүүн Р.Гончигдорж “Өнөөдрийн хуралдаан бол Хууль зүйн байнгын хороо бүрэн эрхийнхээ дагуу зохион байгуулж байгаа хурал юм. Заавал УИХ-ын чуулганаар оруулж хэлэлцэх албагүй. Хууль зүйн байнгын хороо өөрийн бүрэн эрхийн хүрээнд тогтоол гаргаж хуулийн байгууллагаар хянуулах эрхтэй” гэлээ. Энэ мэтээр маргаан үргэлжилсээр МАН-ын бүлэгт 30 минутын завсарлага өгсөн юм. Гэсэн ч дугаар шилжих мөчид Хуульзүйн байнгын хорооны танхимд нэг ч гишүүн байхгүй, хуралдаан эхлээгүй байлаа. Юутай ч эх сурвалжийн өгсөн мэдээллээр улс төрийн намууд Ерөнхийлөгчтэй уулзаж зөвшилцөлд хүрсэн учраас байнгын хороог дахин хуралдуулах шаардлагагүй гэж үзэн хуралдааныг цуцалсан гэх мэдээлэл гараад байсан юм.



№	АЙМАГ	ТОЙРОГ	МАН НЭГ ДЭВЧИЙН	ШИЛЖИЛТ	Сонгогчийн тоо	Сонгуулийн иргэд 2012 он	СОНГУУЛИЙН САНАА ӨГСӨН СОНГОЧИЙН ТОО	сонгуулийн дүнг нэмэлтээр үзье
1	Баянганай	1	Мөнхбат МАН-ынхон	603	19561	68%	13001	85%
2	Хөвсгөл	10	Мөнхбат	708	26833	76%	18432	59%
3	Хөвсгөл	10	Дамбуур	43	11414	65.7%	2678	23.5%
4	Хөвсгөл	10	Дорнод	2400	26592	68.9%	18276	68.6%
5	Баянхонгор	7	Занданатар	257	17433	71.3%	12429	2%
6	Баянхонгор	8	Баял	98	18095	67.1%	12141	0.8%
7	Баянхонгор	8	Баял	98	18095	67.1%	12141	0.8%
8	Увс	11	Ноймолсүх	2802	16848	70%	13843	18%
9	Увс	12	Цэрэнбат	148	16153	66.6%	10923	1.3%
10	Увс	13	Хурлыгатар	366	16134	67.9%	11025	1.3%

Д/д	Өвөг	Нэр	Хаяг	Шилжих ирсэн өгсөн
1	Ханжиряа	Мягмаржав	2-6-35	2016.02.25
2	Булнарзал	Мягмаржав	2-6-36	2016.02.25
3	Мягмаржав	Гантуяа	2-6-37	2016.02.25
4	Дэн	Болоржав	5-10-604	2016.03.01
5	Мэндбаяр	Сэрэнбаяр	5-10-604	2016.03.01
6	Цэрэнном	Золбоо	5-10-604	2016.03.17
7	Самдан	Солонго	5-10-604	2016.03.17
8	Лхагва	Мягмарсүрэн	5-10-604	2016.03.17
9	Дамбуур	Цэндзориг	5-10-604	2016.03.17
10	Баят	Сурмажорол	5-10-604	2016.03.17
11	Жамьяндорж	Энхцэдэг	5-10-604	2016.03.17
12	Дорнод	Цэндзориг	5-10-604	2016.03.17
13	Дэлгэр	Батзориг	5-10-604	2016.03.17
14	Далай	Саруул	5-10-604	2016.03.17
15	Тэмэр	Сарынзориг	5-10-604	2016.03.17
16	Цэрэнном	Зоригт	5-10-604	2016.03.17
17	Бат-Эрдэнэ	Батзориг	5-10-604	2016.03.17
18	Лосонг	Уулзаа	5-10-604	2016.03.17
19	Цэцэг	Цэндзориг	5-10-604	2016.03.17
20	Цэцэг	Дэлгэржав	5-10-604	2016.03.18
21	Бат-Олзий	Бурзанаасга	5-10-604	2016.03.18
22	Алтанжуу	Энхбаттуул	5-10-604	2016.03.18
23	Дорнод	Бухдуу	5-5-15	2016.03.30
24	Ядан	Жамьянсүрэн	5-5-15	2016.03.30
25	Идэнсүрэн	Алтанцэцэг	5-5-15	2016.03.30
26	Батбаяр	Жамьянсүрэн	5-5-15	2016.03.30
27	Батбаяр	Улаанбаатар	5-7-37	2016.03.31
28	Чулуунбаатар	Давуудулам	5-7-37	2016.03.31
29	Нарансүрэн	Энхчүү	5-7-37	2016.03.31
30	Чулуунбаатар	Давуудулам	5-7-37	2016.03.31
31	Товуудорж	Чулуунбаатар	5-4-23	2016.03.31
32	Дашпилжав	Энхбаттар	5-4-23	2016.03.31
33	Пүрэвэ	Амарбаяр	5-4-23	2016.03.31
34	Будлуу	Дэлгэрсүрэн	5-4-23	2016.03.31
35	Чулуу	Цолос	1-4-05	2016.03.31
36	Гундэн-Базар	Отгонцэдэг	5-4-65	2016.03.31
37	Пүрэвэ	Аллага	1-А-23	2016.03.31
38	Мөнхдаш	Хулан	1-А-23	2016.03.31
39	Зайзид	Туяа	1-6-26	2016.03.31
40	Долгоржав	Эрдэнэбаата	1-6-26	2016.03.31

#### АСЕМ-11

## АЗИ, ЕВРОП ТҮМНИЙ ХИ ЧУУЛГАН БОЛЖ БАЙНА



Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Аливаа улсад нийгмийн байгууллыг бие гэж үзэх юм бол түүний зүрх сэтгэл нь ард түмэн юм. Түүний зүрх сэтгэл нь олон нийтийн байгууллага юм. Төрийн бус байгууллага юм. Монгол Улсад олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоог ингэж хүлээж авдгийг хэлнэ. Аливаа улс орны хөгжлийг хүн нь, ард түмэн нь хөтөлдөг. Тэр хөтөлгөч нь институтын хувьд олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллагууд гэж харж байгаа. Ер нь Монголын хөгжлийн философи нь иргэддээ тулгуурладаг юм гэж би хардаг. Манай улсын иргэд эрхтэй байх ёстой. Манай улсын иргэд нийгмийн амьдралд, улс төрийн амьдралд, бүхий л амьдралд идэвхтэй оролцох ёстой. Манай улсын иргэд илүү боломжтой байх ёстой. Энэ нөхцөл байдлыг хангахын төлөө төр нь ажилладаг. Иргэддээ үйлчилдэг. Ийм л байгууллага

гэж бид үздэг. Тэгэхээр Монгол Улсын хөгжлийн философи бол илүү эрхтэй, илүү оролцоотой, илүү боломжтой ард иргэд гэж үзэж болно. Ингэж байж л Монгол Улс цэцэглэн хөгжино, урагшилна гэж бид үздэг. Монгол Улсын хөгжлийн хамгийн гол хөдөлгөгч хүч нь манай ард иргэд юм. Тэдний өмнө явдаг хүмүүс нь зохион байгуулалтад орсон нийгмийн идэвхтэй иргэд юм. Энэ иргэдийн хүч, хөдөлмөрийг бид асар их үнэлэхийг эрмэлздэг” гэдгийг онцлолоо. Мөн саяхан болсон Монгол Улсын Ерөнхийлөгч, ОХУ-ын Ерөнхийлөгч, БНХАУ-ын дарга нарын дээд төвшний уулзалтын талаар дурьдлаа. Энэ талаар “Монголын газар нутгаар дамжин өнгөрөх тээврийн асуудал, төмөр замын асуудал, түүнтэй холбоотой татвар, шалгалт зэрэгтэй холбоотой асуудлыг бид яригдсан. Маш чухал баримт бичгүүдэд гарын үсэг зурлаа. Монголчууд нэг зүйлээр бахархдаг. Бид Ази-

орхиод буцна. Хөөрхий иргэд тэдний бүртгийг цэвэрлээд л буурин дээрээ тойрогтоод хоцорно. Засаглал, эрх мэдлээ батжуулсан Засаг дарга нарын хорхойтой шүдэнд зуугдсан ардчиллыг дэмжигчдийн хэд нь ирэх 2020 оны УИХ-ын сонгууль хүртэл тэсэх юм бүү мэд. Ийм амьдралыг гэмт хэрэгтнүүд хүн царцаагаар дамжуулан алс бөглүү сум, суурингийн иргэдэд “бэлэглэв.” Жинхэнэ царцаасан бол химийн аргаар дахиж өндийхгүй болтол нь нам устгахсан. Харин хүн царцааг яаж ч болдоггүй аж. Ямар нүүдэллэж явахад нь лалынхан шиг автобус юутай хээтэй нь устгалтай биш. Тиймээс тэднийг төрийнхөө эсрэг боссон гэмт хэрэгтнүүд гэж нэрлээд төмөр нүүрээ харуулан зохих шийтгэлийг нь ногдуулахыг харах л үлдлээ.

## Дугаарын 60 мөр

### Төрийн албаныхан ажлаа хийхээ больжээ

Үргэлжлэл.  
Түрүүч нь I нүүрт

Фэйсбүүк, твиттер хуудсаар баахан тархав. Мэдээж төрийн албан хаагчид энэ явган ярианы “шуурга”-нд өртөлгүй яахав. Тийм болохоор төрийн албаныхан яах учраа олохгүй, халагдах нь тодорхой юм чинь ажил хийж яахав гэсэн байдалтай өдрний өнгөрүүлж байх шиг. Ерөөс нэг дарга, сайд, эсвэл улс төрийн хүчин солигдох үед төрийн албан хаагчид хөдөлгөөнд ордог зүй тогтоол өнөөдрийг хүртэл байсаар байгаа. Ямар ч хүн дарга болсон өөрийнхөө багийг бүрдүүлдэг уламжлалтай. Нэг талаа үзэл бодол таарахгүй хүмүүстэй хамт ажиллах хэцүү байдаг байх. Тэр ч утгаараа сольдог болов уу. Нөгөө талаас төрийн албан хаагчид намын харьяаллаас татгалзсан нэртэй л болохоос начир дээрээ хэрэгжсэн юм байхгүй илтгэх аж. Одоог болтол намчирхсан л байна. Тиймдээ ч өөр намын дарга ирэхээр хамтарч ажиллахын оронд өөр ажил олж хийсэн нь дээр гэсэн сэтгэхүйтэй болсон хэрэг. Угаас өнгөрсөн жилүүдийн улс төр ийм байдалд хүргэчихсэн. Нөгөө талаар, МАН-ын дарга нарын нийслэлээс 60 тэрбум төгрөгийн санхүүжилт босгож, сонгуулийн дараа төрийн албыг тэр чигээр нь солихоор ярилцаж байгаа бичлэг гарсан. МАН одоо олонхи болсон, тэд ямар ч байсан ялалт байгууллаа. Тэгэхээр өнөөх мөнгө татсан хүмүүсээ ажлаар хангах өртэй болсон байж таарах нь. Тиймээс төрийн албаныхныг “үсгүй арчиж”, бүгдийг нь халаад, мөнгө өгсөн хүмүүсээ шаг дараатайгаар дарга болгож таарна гэж яриа байгаа юм. Өнөөх мөнгөөр суудал худалдаж авч байгаа дарга нар нь өөрсдийнхөө хүмүүсийг, хамаатан садан, найз нөхдөө авч таарна. Тэдэнд төрийн алба мэргэшсэн, мэргэжлийн байх нь огт падгүй. Дээрээс нь АН-ынхныг ажиггүй болгож “сэтгэлийн таашаал” мэдэрнэ. Ийм л улс төр хэд хоног явах нь.

Төрийн алба ч үндсээрээ сугарах нь. МАН-ын удирдлагуудын авчирч тарих шинэ хүмүүс нь ирэх дөрвөн жилд уграх гэсээр байтал юун ажил үргэлжлүүлэх, ёстой хол хэвтэнэ дээ. Өнөөх нийслэлийнхний хийж байсан ажил бүгд зогсох нь тодорхой байх. Зам засвар, тохижилт, дахин төлөвлөлт, “Сайн хашаа” хөтөлбөр гээд ард түмэнд хэрэгтэй бүх ажил зогсоно. “Тудамж төсөл” хог дээр гарна. Сард худал хэлсэн хүнд хоёр удаа хог ачдаг байсан цаг ард хоцорч, хашаандаа хогоо овоолдоо, аргаа барахдаа өөрсдөө хаана ч хамраагүй аваачиж хаядаг эртний “сайхан” цаг эргэж ирэх нь бололтой. Ийм сэтгэлгүй ч иргэдэд төрөөд эхэлчихэж. Ямар ч байсан ойрын үед төрийн албаныхныг хараад нэмэргүй нь. Ядаж байхад зуны амралтууд эхэлж байгаа ч хэлэх үү. Долоо, наймдугаар сард төрийн албыг хуйгаар нь солинод, есдүгээр сараас нэг юм ажлынхаа учрыг олох гэсэн баахан нөхдүүдтэй ард түмэн үзэлцэх болох нь дээ. Одоо яая гэхэв, бид ийм л сонголт хийсэн хойно. Өнгөрсөн борооны хойноос цув нөмөрч ханахгүй л ард түмэн юм дээ. МАН-ын дарга нарын төлөвлөгөө хэрэгжиж дуусахыг хүлээгээд бухимдаж, уурлаад л явж байхас. Төрийн албан хаагчид ч гэсэн байрны мөнгөө хэрхэн төлөх, найман хувийн найдваргүй зээлдэгч болохгүйн тулд амарч зулаахаа азнаж зуны турш ажил хайсан ч гэмгүй биз.

## УЛС ТӨР

СОНГУУЛЬ-2016

...Засаг даргаар нэр дэвшсэн Су.Батболдын УИХ-ын мөрийн хөтөлбөр нь дуусаагүй гэсэн. Тиймээс хурлыг хойшлуулж байна...



## Д.БАТТУЛГА:

# МАН-ЫНХАН БОЛОМЖОО ЭДЭЛЖ ЧАДСАНГҮЙ

Ж.ОТГОН

*Нийслэлийн ИТХ-ын анхдугаар хуралдаан өчигдөр болох тов гарсан билээ. Хуралдаанаар Нийслэлийн ИТХ-ын сонгууль явуулсан дүн, бүрэн эрхийг зөвшөөрөх тухай, нийслэлийн ИТХ-ын даргыг сонгох, нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тоог тогтоож, Тэргүүлэгчдийг сонгох, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэх байсан. Гэвч тус хуралдаан хотын даргын ажлыг хүлээж авах УИХ-ын гишүүн Су.Батболдын бүрэн эрх дуусаагүйгээс шалтгаалж хойшиллоо. Хэрвээ УИХ-ын анхдугаар хуралдаан өнөөдөр болж шинэ гишүүд тангарагаа өргөж, хуучин гишүүдийн бүрэн эрх дуусгавар болчихвол өнөөдөр үдээс хойш хуралдаж магадгүй аж. Энэ талаар нийслэлийн ИТХ-ын дарга Д.Баттулгаас тодрууллаа.*

**-Анхдугаар чуулганыг яагаад хойшлуулахаар болсон юм бэ?**

-ИТХ-ын долоо дахь удаагийн сонгуулийн дүн гараад байна. Анхдугаар чуулганыг манай

МАН-ын нөхдүүд өнөөдөр /өчигдөр/ хуралдуулах саналыг надад албан ёсоор тавиад байсан. Нэгдүгээрт, энэ хүсэлтийг нь харгалзаад, хоёрдугаарт Улаанбаатарт

хотод тулгамдаад байгаа олон асуудлууд байна. Наадам, АСЕМ болон урин дулаан цагт нийслэлд хийгдэх ёстой бүтээн байгуулалтын асуудлууд гээд олон асуудал байгаа. Тиймээс ч тэдний хүсэлтийг харгалзаад, маш хурдан хурлаа хуралдуулж, дараагийн хүмүүстээ ажил хийх боломжийг нь олгох үүднээс хурал зарлаад байсан. Харамсалтай нь надад МАН-ын нөхдүүдээс буюу хотын МАН-ын хорооноос бичиг ирүүлсэн. Засаг даргаар нэр дэвшсэн Су.Батболдын УИХ-ын мөрийн хөтөлбөр нь дуусаагүй гэсэн. Тиймээс хурлыг хойшлуулж байна.

**-Хотын даргаас өмнө ИТХ-ын дарга болоод тэргүүлэгчдээ сонгож болохгүй байсан юм уу?**

-Миний бодлоор МАН-ын нөхдүүд өнөөдөр /өчигдөр/ товлосон цагтаа хуралдаад, хурлынхаа даргыг сонгоод, тэргүүлэгчдээ сонгож болно. Харин Засаг даргынхаа асуудлыг маргааш /өнөөдөр/ болтол хойшлуулах боломж байсан. Гэвч харамсалтай нь МАН-ынхан боломжоо эдэлж чадсангүй. Шалтгааныг нь би хэлж мэдэхгүй байна. Тиймээс тэргүүлэгчдийг маргааш өглөө 11:00 цагт хуралдуулах чиглэл өглөө. Тэргүүлэгчид дараагийн чуулганы товийг бүрэн эрхийнхээ хугацаанд шийдэх болно.

**-Чуулганыг хэзээ хуралдуудахаар болов?**

-Надад ирсэн мэдээллээр маргааш /өнөөдөр/ УИХ-ын анхдугаар чуулган хуралдах юм шиг байна. Тиймээс тус хурлаар дараагийн УИХ-ын гишүүд нь тангараг өргөснөөр хуучин УИХ-ын гишүүдийн бүрэн

эрхийн хугацаа дуусгавар болох байх. Анхдугаар хуралдааныг маргаашин /өнөөдрийн/ 14:00 цаг хүртэл хойшлуулж өгөөч гэх хүсэлтийг надад өглөө.

**-Хотын даргаас өмнө ИТХ-ын дарга болоод тэргүүлэгчдээ сонгож болохгүй байсан юм уу?**

-Миний бодлоор МАН-ын нөхдүүд өнөөдөр /өчигдөр/ товлосон цагтаа хуралдаад, хурлынхаа даргыг сонгоод, тэргүүлэгчдээ сонгож болно. Харин Засаг даргынхаа асуудлыг маргааш /өнөөдөр/ болтол хойшлуулах боломж байсан. Гэвч харамсалтай нь МАН-ынхан боломжоо эдэлж чадсангүй. Шалтгааныг нь би хэлж мэдэхгүй байна. Тиймээс тэргүүлэгчдийг маргааш өглөө 11:00 цагт хуралдуулах чиглэл өглөө. Тэргүүлэгчид дараагийн чуулганы товийг бүрэн эрхийнхээ хугацаанд шийдэх болно.

МЭДЭЭ

## Герман, Монголын залуу улстөрчид туршлага солилцох нь

Ц.СОЛОНГО

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман улстай Дипломат харилцаа тогтоогоод 40 гаруй жил өнгөрчээ. Энэ хугацаанд хоёр улс боловсрол, үйлдвэрлэл болон бусад салбарт үр бүтээлтэй хамтран ажиллаж, олон улсын тавцан дахь хоёр улсын байр суурийг харилцан хүндэтгэж ирсэн билээ. Тэгвэл энэ харилцааг улам бүр батжуулах, хоёр улсын улс төрд бэлтгэгдэж буй залуучуудад ажил, мэргэжил, салбарын туршлага солилцох боломжийг бүрдүүлэх зорилгоор хоёр улсын залуу улстөрчдийн чуулга уулзалтыг зохион байгуулах талаар хуралдааныг зохион байгуулагчид хэвлэлийн хурал хийлээ. Чуулга уулзалт энэ сарын 8-нд Төрийн ордонд болох бөгөөд уулзалтын хүрээнд хоёр улсын хамтын найрамдал, ирээдүйн хөгжлийн асуудлаар нээлттэй хэлэлцэж үүгээр дамжуулан хоёр улсын залуу улстөрчид туршлага солилцох, улс төрийн мэдлэгээ тэлэх, хамтарсан бүтээлтэй ажиллагаа хийх эхний алхам болно гэдгийг хуралдааныг зохион байгуулагчид онцолж байлаа. Ерөнхий зохион байгуулагч Б.Мөнх-Эрдэнэ "Монгол, Герман улстөрч залуусын анхдугаар чуулганыг зохион байгуулах гэж байна. Үүгээрээ Герман улстөрчийн харилцаа холбоог өргөжүүлэх бүх салбарт туршлага суулгах зорилготой ес хоногийн айлчлал болох юм. Энэхүү чуулга уулзалтын ерөнхий зохион байгуулагчаар Герман Монголын хамтарсан "Отгобаяр" сан, ЦСҮ намын Айхах Фриэдбэрг хотын залуучуудын холбоо, Ханс Зайделийн сан зэрэг ажиллаж байна. Мөн зохион байгуулагчаар "Монгол-Германы Гүүр" ТББ, MBDC, Социетер Олон улсын Эмэгтэйчүүдийн холбоо ажиллаж байна" гэв. Мөн МАН-ын дэргэхэд НАМОХ-ны Ерөнхийлөгч Д.Гантулга "Монгол, Герман залуучуудын хамтын ажиллагаа уулзалтын олон сарын өмнөөс бэлдсэнээр энэ сарын 8-ны өдөр 11 улстөрч залуучууд Монгол Улсад айлчилж ирэхээр болоод байна. Уулзалтаар хэвлэл мэдээллийн, улс төрийн болон олон талаар хамтран ажиллаж, цаашид хамтарч ажиллаж байсан ажлаа өргөжүүлэх боломжтой гэдгийг дуулгахад таатай байна. Энэ уулзалтад бүх намын залуучууд нэгдэн оролцож хоёр орны намын талаар үзэл бодлоо илэрхийлнэ. Ирэх есдүгээр сард бид бүхэн Монгол Улсаа төлөөлж Герман улс руу зорьж уулзалт хийнэ" гэв.

## ХҮН улс төрийн шинэ хүчин гэдгээ нотоллоо гэв

Хөдөлмөрийн үндэсний намын /ХҮН/ гишүүд УИХ-ын сонгуульд намаараа орж чадаагүй ч сонгуульд бие даан оролцож улс төрийн шинэ гуравлагч хүчин гэдгээ нотоллоо хэмээн тус намын төлөөлөгчид өчигдөр мэдээлэл хийлээ. Энэ удаагийн УИХ-ын сонгуульд ХҮН-аас 19 нэр дэвшигч бие даан өрсөлдөж, МАН болон Ардчилсан намын араас жагссан. Тухайлбал, 70 дугаар тойрогт нэр дэвшсэн Х.Ганхуяг 24.1 хувь, 57 дугаар тойрогт Т.Доржханд

20.7 хувийн санал авч нийт өрсөлдсөн тойргуудын хүрээнд дунджаар 8.1 хувь буюу 26 мянга гаруй санал авсан гэдгийг ХҮН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Д.Гантулга хэллээ. Шинээр бүрэлдэх Засгийн газрын хувьд эдийн засгийн байдлыг хамтын хүчээр шийдэх зарчмын байр суурьтай байгаа. Бид шүүмжлээд суух биш өөрсдийн зүгээс дэмжлэг үзүүлж, мэргэжлийн боловсон хүчнээ бүрэн дайчилж ажиллах болно гэлээ.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

...Ардчилсан намын Шинэчлэлийн хөдөлгөөнөөс санаачлага гарган АН-ыг шинэчлэх түр хороог зохион байгуулан намын төв байранд байрлах болсныг мэдэгдэж байгаа аж...

Ж.ӨӨДТӨН

АН-ын шинэчлэх түр хороо байгуулагдсан байна. Тус хорооны төлөөлөл намын төв байранд өчигдөр мэдээлэл хийлээ. Түр хорооны гишүүн П.Галиндэв "Монголын ард түмэн өмнөх сонгуулиар АН-д их итгэл хүлээлгэж УИХ-д олуулаа болгож өгсөн. Улмаар манай нам сонгогчдын дэмжлэгийг нэмэгдүүлэх олон сайн ажлыг санаачлан эхлүүлсэн. Улс орон даяар их бүтээн байгуулалт өрнүүлж, нийслэлийг нийслэл шиг болгох эхлэлийг тавьсан гээд олон ажлыг нэрлэж болно. Харамсалтай нь нам дамнансан эдийн засгийн бүлэглэл, нам доторхи фракц хоорондын утга учиргүй зөрчилдөөнд хэт автан өөрсдийн



байгуулсан Засгийн газраа огцруулж, 1996-2000 оны гашуун түүхээ давтсан. Мөн алсын хараагүй шийдвэрүүд гаргаж, жирийн шударга гишүүдийнхээ дуу хоолойг боож, үнэт зүйл, зарчмуудаа уландаа гишгэсэн, ёс зүйгүй гишүүдийн дүрэмгүй "тоглолт"-ыг дэвэргэн, улс төрийн алдаатай бодлого явуулсан удирдлагуудын байр суурь зэрэг нь намын нэр хүндийг ихээр унагааж, энэ удаагийн УИХ болон аймаг, нийслэлийн сонгуульд АН-ыг бүрэн ялагдаууллаа. АН-ын Шинэчлэлийн хөдөлгөөн дээрх байдлыг жил гурван сарын өмнөөс АН-ын одоогийн удирдлагуудад анхааруулж, баярын хурал дээр лоозон өргөж хүртэл шүүмжилж байсан төдийгүй, удаа дараагийн шаардлагуудыг хүргүүлж байсан. Гэвч тухайн үед эрх мэдэл, тойрон хүрээлэгчдийнхээ магтаалд хэт автсан намын удирдлагууд алдаа дутагдлаа ойлгохгүй явсаар нийм байдалд хүргэлээ" хэмээлээ. Харин түр хорооны гишүүн Г.Хажидмаа

МЭДЭЭЛЭЛ

## Д.Оюунхоролын шадар туслах хууль зөрчөөгүй гэв

УИХ-ын сонгуулийн 49 дүгээр тойрогт МАН-аас нэр дэвшсэн Д.Оюунхоролын шадар туслах Н.Энхзаяаг сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуулийн хууль зөрчсөн гэж үзсэн. Улмаар Баянзүрх дүүргийн эрүү, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 95 дугаар шийтгэвэрээр хэрэг үүсгэсэн билээ. Тэгвэл энэхүү хэргийн давж заалдах шатны шүүх хурал энэ сарын 1-ний

өдөр Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхэд болж шүүхээс уг шийтгэврийг хүчингүй болгожээ. Өөрөөр хэлбэл, нийслэлийн эрүүгийн давж заалдах шатны шүүхийн 20 тоот магадлалаар Баянзүрх дүүргийн эрүү, захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хууль ёсны бус, үндэслэлгүй болохыг тогтоолоо.

## "Бүх аймаг, сумдад сонгууль хуулийн дагуу явагдсангүй"

Б.САРНАЙ

УИХ-ын 18 дугаар тойрогт МАН-аас нэр дэвшсэн Ш.Батсамбуугийн өмгөөлөгчдийн баг болон Завхан аймгийн сонгогчдын төлөөлөл "18 дугаар тойрогт гарсан зөрчил"-ийн талаар мэдээлэл хийлээ. Хуралд өмгөөлөгч М.Мөнхжаргал, О.Мөнхболд, М.Цэнгүүн болон иргэн М.Банзрагч нар оролцсон юм. Хурлын үеэр өмгөөлөгч М.Мөнхжаргал хэлэхдээ "Бүх аймаг, сумдад сонгууль хуулийн дагуу явагдсангүй. Тодруулбал, Завхан аймагт намуудын сонгуулийн штабын ажилтнууд, санал тоолох үйл ажиллагааг зохион байгуулсан хэсгийн ажилчид өөрсдөө хууль зөрчсөн. 18 дугаар тойрогос сонгогдсон УИХ-ын гишүүн З.Нарантуяа болон Ардчилсан намын сонгуулийн штабтай холбоотой хэд хэдэн зөрчил, асуудлыг шалгуулахаар цагдаагийн байгууллагад өгсөн байгаа. Эдгээр зөрчилд

Завхан аймгийн Ардчилсан намын сонгуулийн штабаас сонгуульд ажиллаагүй энгийн иргэн, сонгогчид мөнгө тараасан, нэр дэвшигч өөрөө төгсөгчдийн уулзалтад оролцож, шагнал гардуулсан нь Сонгуулийн тухай хуулийн 70.1.4-т заасан нийтийг хамарсан биеийн тамирын уралдаан, тэмцээн зохион байгуулж, ивээн тэтгэсэн гэх заалтыг зөрчсөн гэж үзэж байна" гэлээ. Мөн Улиастай сумын Жинст багийн зөвхөн нэг саналын машинаас 230 орчим тамга тэмдэггүй саналын хуудас илгэсэн. Чигэстэй, Өлзийт, Жаргалант, Товцог багууд болон Алдархаан, Шилүүстэй сумдын санал унших төхөөрөмжид уншигдсан саналын хуудаснаас тамга тэмдэггүй 172 ширхэг саналын хуудас гарсан. Нийтдээ 402 саналын хуудас гарсан. Мөн саналын хуудас дутаж канондсан. Канондсан 33 хуудаснуудыг хар хайрцаг уншихгүй, гараар толсон гээд олон зөрчил илэрсэн гэлээ.

# АН-ын удирдлагуудыг 24 цагийн дотор огцрохыг шаардлаа

"Ардчилсан намыг эдийн засгийн бүлэглэл, фракц, ёс зүйгүй гишүүдээс бүрэн цэвэрлэж, хариуцлага ёс зүйн тогтолцоог нэвтрүүлэн, Их хурлаа хуралдуулан үзэл баримтлал, Үндсэн дүрэм, бүтэц зохион байгуулалтаа өөрчлөн улс орныхоо ирээдүйн хөгжлийг тогтвортой бодлогоор манлайлах бодлогын нам болгон эрс шинэчлэх үйлсэд 21 аймаг есөн дүүргийн нийт гишүүд, дэмжигчдийг идэвхитэй оролцож, намын төв байран дээр ирж бидэнтэй нэгдэхийг уриалж байна" гэв.

Ардчилсан намын Шинэчлэлийн хөдөлгөөнөөс санаачлага гарган АН-ыг шинэчлэх түр хороог зохион байгуулан намын төв байранд байрлах болсныг мэдэгдэж байгаа аж. Улмаар тус хорооноос хэдэн хэдэн шаардлагыг АН-ын дарга З.Энхболд, Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч Л.Эрхэмбаяр болон бусад удирдлагуудад шаардлага хүргүүлж байгаа юм байна. Тодруулбал, Намын дарга, Ерөнхий нарийн

бичгийн дарга нар намын нийт гишүүд дэмжигчдээсээ өөрийн биеэр уучлалт гуйж, хариуцлага хүлээн, огцрох өргөдлөө 24 цагийн дотор гаргах, АН-ын Гүйцэтгэх зөвлөл, ҮЗХ-г 48 цагийн дотор яаралтай хуралдуулж Намын их хурлыг наймдугаар сарын 15-ны дотор зарлах гэнэ. Ардчилсан намыг шинэчлэх түр хороонд дараах эрхүүдийг шилжүүлэн өгөхийг хүсчээ.

1. Ардчилсан намын ээлжит бус /онц/ Их хурлыг нэн даруй зохион байгуулж хуралдуулах
2. Намын их хурлаас ил тод, нээлттэй, өрсөлдөөний зарчмаар АН-ын Шинэ удирдлагуудыг сонгох
3. АН-ын Үндсэн дүрэмд өөрчлөлт оруулах
4. Намын ГЗ, ҮЗХороог 100 хувь өөрчилж, намын дунд шатны байгууллагуудын хурлаас шинэчлэн сонгох.
5. Намын Үндсэн дүрэмд орсон өөрчлөлтөд нийцүүлэн аймаг, нийслэлийн намын хороодыг шинэчлэн зохион байгуулах.

# ОНЦЛОХ ХУУДАС

## Сенсаацийн эргэн тойронг

# УСАНД ОСОЛДОХ НЬ ИХЭСЧЭЭ

Манайхан зун болохоор л амралтын өдрөө ая тухтай өнгөрүүлж, зугаалж, наргиж өнгөрөөх нь ихэсдэг. Бүр гэр бүл, найз нөхдөрөө нийлээд, хээр гарч, гол усанд тоглоно. Ингэж амарч, зугаалах нь мэдээжийн хэрэг сайхан. Гэвч амарч зугаалахдаа анхаарал болгоомжгүй, архидан согтуурснаас үүдэн гол усанд орж амиа алдах нь ихэсдэг. Бэлхүүсээр татсан усанд живдэг хүн гэж хаа байх вэ гэж ирээд л усыг басах тохиолдол ч бий. Ойрын өдрүүдэд халуун байгааг ч хэлэх үү монголчууд гол ус бараадаж, Туулын эрэг хүнээр дүүрэх болсон байна. Үүнтэй холбогдуулаад ОБЕГ-т ч усанд осолдлоо, живлээ, усаар аялаад сураггүй алга боллоо гэсэн дуудлага өдөр бүр ирэх болжээ. Тиймээс энэ удаагийн "Онцлох хуудас" булангаа сэрэмжлүүлэх үүднээс бэлтгэлээ.

### УСАНД ОСОЛДСОН ЗАЛУУСЫН ЦОГЦОС ОЛДСОНГҮЙ

2016.07.03

Гол мөрний усанд осолдож эндсэн хүмүүсийн олонхи нь залуус байгаа аж. Тухайлбал, Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Шар-Ус багийн "Хонхор"-ын задгайд оршин суугч 21 настай, эрэгтэй Н тус багийн "Суу толгой" гэдэг газар Орхон голын усанд осолдсон ч цогцос нь олдоогүй тухай ОБЕГ-ын албан сайтад мэдээлжээ. Сэлэнгэ аймгийн ОБГ-ын 11 албан хаагч, цагдаагийн байгууллагын хоёр албан хаагч, орон нутгийн 43 иргэн, нийт 60 хүн зургадугаар сарын 25-30-ны өдрүүдэд усанд эндсэн залууг эрж хайгаад олоогүй гэнэ. Шар-Ус багийн Орхоны гүүрнээс, Хушаатын гүүр хүртэл 150 км, Суу толгой гэдэг газраас Хар хошуу гэдэг газар хүртэл усаар 80 км, Суу толгойгоос-Орхоны гүүр хүртэл 80 км нийт 310 км газарт самналт хийгээд олоогүй тул эрлийг зогсоожээ. Мөн Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ сумын Хөндий багийн "Хар-Ус" гэдэг газар /сумын төвөөс хойд зүгт 25 км/ тус аймгийн Алаг-Эрдэнэ сумын харьяат 24 настай, эмэгтэй Н зургадугаар сарын 27-ны өдрийн 14:30 цагт Шишгэдийн голын усанд осолдсон байна. Аврагчид голын усанд шумбалт хийж, голын хоёр захаар завьтай эрэл хийсэн ч усны гүн 4-9 метр, булингартай, харагдах орчин муу байсан тул олоогүй гэнэ. Тиймээс эрлийг зогсоожээ.

### АЯЛАЛД ГАРААД СУРАГ АЛДАРЧЭЭ

2016.06.26

Завхан аймгийн Идэр сумын "Идэр"-ийн голоор Швейцарийн холбооны улсын иргэн 69 настай Б өнгөрсөн гавдугаар сарын 24-ний өдөр завьтай аялалд гараад, хамгийн сүүлд Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын "Олон голын бэлчир" гэдэг газар Сэлэнгэ мөрөнд зургадугаар сарын 10-ны өдөр явж байгаад ор сураггүй болсон тухай дуудлага зургадугаар сарын 21-ний өдрийн 14:20 цагт онцгой байдлын газарт иржээ. Дуудлагын дагуу тус аймгийн Онцгой байдлын газрын зургаан алба хаагч 21-ний өдрийн 16:00 цагаас эхлэн Дэлгэрмөрөн голын "Хилэнт"-ийн гүүрнээс завьтай эрэн хайх ажиллагааг зохион байгуулж, 24-ний өдрийн байдлаар Тариалан сумын Сэлэнгэ багийн нутаг "Нүхтийн үзүүр" гэдэг газар хүртэл нийт 300 км усаар урсч, мөн өдрийнхөө 19:30 цагт эрлийн ажиллагааг зогсоожээ. Тэгвэл усанд осолдсон уг иргэдийг энэ сарын 2-нд олж чаджээ.

### ТӨВ АЙМГИЙН ЗААМАРТ 13 НАСТАЙ ОХИН ГОЛЫН УСАНД ОСОЛДЖЭЭ

2016.06.27

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын Шар-Ус багийн Хонхорын задгайд оршин суугч иргэн 21 настай, эрэгтэй Н тус багийн "Суу толгой" гэдэг газар Орхон голын усанд осолдсон тухай дуудлага зургадугаар сарын 25-ны өдрийн 17:24 цагт ирсэн байна. Дуудлагын дагуу аймгийн Онцгой байдлын газрын 15 албан хаагч, цагдаагийн байгууллагаас хоёр албан хаагч, орон нутгаас 43 иргэн, нийт 60 хүн эрэн хайх ажиллагааг тус тус явуулж байгаа аж. Мөн Төв аймгийн Заамар сумын Хайлааст багийн "Дорголт" гэдэг газар Туул голын усанд 13 настай, эмэгтэй О осолдсон тухай дуудлага зургадугаар сарын 25-ны өдрийн 20:22 цагт иржээ. Дуудлагын дагуу тус аймгийн Онцгой байдлын газрын зургаан албан хаагч эрэн хайх ажиллагааг зохион байгуулжээ. Эрэн хайх ажиллагаа 13 цаг үргэлжилж, зургадугаар сарын 26-ны өдрийн 09:15 цагт охины цогцсыг Туул голд анх орсон газраас 30 метрийн зайд, хоёр метрийн гүнээс гарган аймгийн Цагдаагийн газрын жижүүрийн бүрэлдэхүүнд хүлээлгэн өгчээ.



### САНАЛАА ӨГЧИХӨӨД БУЦАЖ ЯВАХДАА УСАНД ОСОЛДОВ

2016.06.30

Сонгуулийн өдөр ихэнх нутгаар бороо ус элбэгтэй байх тул болгоомжтой байхыг ОБЕГ-аас мэдээлж байсан. Гэвч харамсалтай нь сонгуульд оролцож, саналаа өгчихөөд буцаж яваад голын усанд осолдсон хэрэг гарсан юм. Тодруулбал, Ховд аймгийн Алтай сумын Бодонч багийн нутагт тус сумын харьяат, 26 настай, эрэгтэй М, 21 настай, эрэгтэй А нар тус багийн Цагдууртай голын усанд осолджээ. Аймгийн Онцгой байдлын газар, Булган сумын Гал унтраах, аврах 38 дугаар ангийн албан хаагчид орон нутгийн иргэд нийт 22 хүн, гурван техник хэрэгсэлтэйгээр эрэн хайх ажиллагааг зохион байгуулж, тус багаас 10 км-ийн зайд "Билчир"-ийн гарамнаас 26 настай, эрэгтэй М-ийн цогцсыг олж, цагдаагийн байгууллагад хүлээлгэн өгсөн байна.

### ОН ГАРСААР 28 ХҮН УСАНД ОСОЛДОЖ, АМИА АЛДЦАА

2016.07.01

Ойрын өдрүүдэд нийт нутгаар бороо их орсноос болж үер, усны аюул ихэсч байгааг албаныхан хэлж байсан. Энэ талаар Онцгой байдлын ерөнхий газрын цаг уурын асуудал харуцсан мэргэжилтэн Ч.Туяа "Зургадугаар сард нийт нутгаар бороо их орсон. Хөдөө, орон нутагт голуудын усны түвшин их нэмэгдсэн. Зарим нэг ширгэсэн гол, горхи буцаад урсч эхэлсэн учир бороо орох үед үерийн аюул ихэссэн. Үүнтэй холбогдуулаад Онцгой байдлын ерөнхий газраас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх талаар харьяа, салбар нэгжүүддээ үүрэг өгч ажилласан. Нийслэл хот, хүн ам их суурьшсан газарт завьт эргүүл ажиллаж байгаа. Усны осолд хүүхдүүд их өртөж байгаа учраас хүүхдүүддээ анхаарах талаар эцэг, эх асран хамгаалагчдад сэрэмжлүүлэг мэдээллийг олон удаагийн давтамжтайгаар өгч байгаа. Гэхдээ иргэдийн хайхрамж болгоомжгүй байдлаас болоод усанд осолдох тохиолдол гарсаар байна. Өнөөдрийн байдлаар гэхэд нийтдээ 28 иргэн усанд осолдож, амиа алдсан тохиолдол бүртгэгдээд байгаагийн арав нь бага насны хүүхэд байна. Мөн усанд суусан, машинтайгаар урссан гэх дуудлагууд их ирж байгаа. Тиймээс иргэд, тээврийн хэрэгслийн жолооч нар анхаарал болгоомжтой явах хэрэгтэй. Мөн бороо их орж байгаагаар холбогдуулан тогтоол ус бий болсон. Тогтоол усанд хоёроос гурван насны нярай хүүхдүүд унаж, амиа алдсан тохиолдол их гарч байна. Энэ тал дээр эцэг, эх асран хамгаалагчид анхаарал болгоомжоо өндөржүүлээсэй гэж хүсч байна" хэмээсэн юм.

## Сэтгүүлчийн өнцөг

# АМИНДАА ХАЙРТАЙ БАЙЯ

Э.ТУУЛ

Зургадугаар сард бороо хур их орно, гол ус үерлэнэ гэж мөн ч их анхааруулсан даа. Харин манайхан "Бэлхүүсээр татсан усанд живдэг хүн гэж хаа байх вэ. Бүр найз нөхөдтэйгөө явж байж шүү..." хэмээн хэнэггүй царайлж байлаа. Бүр усан дотор суучихаад архи уудаг хүнд гарууд ч олон. Усанд тойрч зогсчихоод нэгнийхээ толгой дээр нь дарж, ус руу шидэлж гарна. Ус залгин хахаж цацаж, чарлалдах тэднийг харан элгээ хөштөл инээлдэх нь энүүхэнд. Гэхдээ инээдэм ханиад болох тохиолдол бий. Үүнийг л сануулах гээд байгаа хэрэг. Түүнээс биш гол усанд очиж тоглож болохгүй гэсэн хатуу чанд дүрэм журам байхгүй. Хамгийн гол нь тухайн хүний сонор сэрэмж, болгоомж хэрэгтэй. Хэнэггүй, юмыг бага гэж голдогоос болж, хэчнээн алтан амь энэ хорвоог орхин одсоныг

харсан биз дээ. Түүнчлэн гол ус үерлэнэ, битгий ус туулаарай гэж сануулсаар байхад зөрүүдэлж очоод ус, шаварт суучихдаг хүмүүс ч бий. Тэд өөрсдийнхөө болон бусдын алтан амь, хөрөнгө мөнгийг үрж байгаагаа ер ойлгодоггүй. Онцгой байдлын аврагчдыг төмрөөр хийчихээгүй. Тэд хэнэггүй хүмүүсийг аврах гэж очоод өөрсдөө ч амиа алдаж мэдэх эрсдэлтэй. Дээрээс нь хөрөнгө мөнгөний тухайд гэвэл аялагч нар өөрсдийнхөө эрүүл мэнд, эдийн засгаар хохироод зогсохгүй улсын өч төчнөөн хөрөнгийг үрнэ. За тэгээд, сүлжээгүй газар очоод машин нь суучихсан, гол усанд осолдчихсон байвал хугацаа алдана. Тэр хэрээрээ л улсын хөрөнгө урсана. Дээрээс нь алтан амиа алдана. Энэ мэтчилэн сэрэмжлүүлээд, сануулаад байхад зөрүүдлээд байдаг нөхөд их болчихжээ. Одоо долдугаар сард ч мөн бороо орно гэж Онцгой байд-

...Тиймээс нийт иргэд, эцэг эхчүүд хүүхэддээ тавих хараа хяналтаа сайжруулж, хүүхдүүдээ гол усны эрэг дагуу явуулж, тоглуулахгүй байх, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэхдээ гол усны ойролцоо амарч зугаалахгүй байх, цаг агаарын мэдээг тогтмол хүлээн...

лынхан анхааруулж сэрэмжлүүлээд эхэлчихсэн. Ер нь баруун зүгийн зарим газраар дундаж хэмжээнээс багавтар, говийн бүсийн нутгаар дунджаас их, бусад нутгаар дундаж хэмжээнд хур тунадас бороо орох төлөвтэй байгаа гэнэ билээ. Одоогоор бороо яг хэзээ орохыг хэлэх боломжгүй, наймдугаар сард ч гэсэн бороо орох төлөвтэй байгааг албаны хүн хэлээд байгаа юм. Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын

хурандаа Н.Уламбаяр "Дулааны улиралд үер усны дуудлага нэмэгддэг. Амралт зугаалганд явж байгаа иргэд гол усанд осолдож, амиа алдах, бэртэж гэмтэх тохиолдол их байдаг. Өнгөрсөн хоёр хоног орсон борооноор улсын хэмжээнд гол усанд 18хүнэндсэнхарамсалтай мэдээ байна. Нийслэлийн хэмжээнд гурван хүн усанд осолдсон байна. Нийслэлийн онцгой байдлын алба нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хурд хүч сайтай

орчин үеийн усны мотоцикль, тийрэлтэт хөдөлгүүртэй завьтай болсон. Энэ техникүүд нь аврах ажиллагааг маш шуурхай болгож байна. Усанд аврах ажиллагааг хийхдээ өмнө нь 20 минут явдаг байсан бол энэ хугацаа хоёр дахин буурлаа. Завьт эргүүлийг Туул гол дагуу жил бүр гаргадаг. Энэ жил мөн Туул гол дагуу завьт эргүүлийг гаргаж байна. Цагаан хоолойгоор голын усны түвшин ямар байгаа мэдээллийг өгч сэрэмжлүүлж байгаа. Бас машин техник усанд боогдох, гэр орон нь үерт автан дуудлага нэлээд их байлаа. Сүхбаатар, Чингэлтэй, Баянзүрх дүүргүүдийн айл өрхүүд үерт автлаа. Ялангуяа Сүхбаатар дүүргийн таван гудамжны 120 гаруй айлын хашаа үерт автсан. Чингэлтэй дүүргийн доод салхитын орчим тав, зургаан айл усанд автсан. Гуу жалга дагуу үерийн аман дээр айлууд их бууж байна. Үерт автаж болзошгүй газар 2500 орчим

айл өрх буусан байдаг. Үерийн аман дээр айл, өрхүүд буухгүй баймаар байна. Өөрсдийн амь насаа эрсдэлд оруулж байгааг анхаараарай гэж сануулмаар байна" хэмээн ярьсан байсан. Тиймээс нийт иргэд, эцэг эхчүүд хүүхэддээ тавих хараа хяналтаа сайжруулж, хүүхдүүдээ гол усны эрэг дагуу явуулж, тоглуулахгүй байх, амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэхдээ гол усны ойролцоо амарч зугаалахгүй байх, цаг агаарын мэдээг тогтмол хүлээн авч, баталгаат зам гүүрээр зорчиж машинаар гол гатлахыг оролдохгүй байх, голын усны түвшин нэмэгдсэн үед голд сэлэхгүй байх ёстой шүү. Хүний үг авахгүй, сэрэмжлүүлж сануулаад байхад тоохгүй гараад явчихдаг гэм манайханд бий болохоор л дахин дахин сануулаад байгаа хэрэг. Уг нь хүн бүхэн анхааралдаа авчихвал заавал үерлэнчихсэн байхад нь гол, ус руу осолдоод байхгүй баймаар.

# ДЭЛХИЙ

## Францын экс Ерөнхий сайд таалал төгсчээ

Францын Ерөнхий сайд асан Мишель Рокар 85 насандаа таалал төгсчээ. Социалист үзэлт Рокар Ерөнхийлөгч Франсуа Миттераны үед 1988-1991 онд Ерөнхий сайдаар ажиллаж байсан юм. Тэрбээр зүүний төвч үзэлт, ЕХ-г тууштай дэмжигч бөгөөд зах зээлийн эдийн засгийг илүүд үздэг нэгэн байжээ. Рокар өнгөрсөн бямба гарагт Парис хотын нэгэн эмнэлэгт таалал төгссөн байна. Гурван жилийн өмнө таалал төгссөн Ерөнхийлөгч Франсуа Миттераныг тэрээр 1998 онд “шударга бус хүн” гэж шүүмжилсний улмаас зөрчил үүсч байжээ. Миттераны үеийн Засгийн газрыг “дээрэмчдийн бүлэглэл” гэж тодорхойлоод “Би Франц улсыг хамгаалахын тулд Ерөнхий сайд болсон” хэмээж байв. Мишель Рокар

1930 оны наймдугаар сард Парис хотноо төржээ. Тэрээр элитийн сургууль гэгддэг Францын Үндэсний их сургуульд суралцан төгсч, Сангийн яаманд ажиллаж эхэлсэн байдаг. Оюутан байх үеэсээ улс төрийн үйл ажиллагаанд шамдаж, 1968 онд Засгийн газрын эсрэг “Тавдугаар сарын хувьсгал”-ыг удирдаж байсан гэдэг. Харин дараа жил нь буюу 1969 онд парламентын доод танхимд сонгогдож, 1974 оны Ерөнхийлөгчийн сонгуульд Социалист намаас нэр дэвшигч Миттераныг дэмжиж, улмаар намд нь элсч байжээ. Ямартай ч, нэрт улстөрч таалал төгссөнд Ерөнхийлөгч Франсуа Олланд “Франц улс болон зүүний үзлийг баримтлагчид аугаа их улстөрчөө алдлаа” хэмээн онцлон тэмдэглэсэн байна.



## Канадын Ерөнхий сайд гейчүүдтэй нэгдэв

Канадын Ерөнхий сайд Жастин Трюдо тус улсын нийслэл Торонто хотноо зохион байгуулагдсан ижил хүйстнүүдийн парадад нэгдэж, бэлгийн цөөнхийнхөнтэй хамт гэдгээ илэрхийлжээ. Канадын түүхэнд анх удаагаа Засгийн газрын тэргүүн нь гей парадад оролцсон

нь энэ байсан аж. Тэрбээр зүүн болон баруун хэсэгт нь бэлгийн цөөнхийнхний өнгө болох солонгын долоон өнгийг дүрсэлсэн Канадын төрийн далбаагаа гаргаа барьж алхсан бөгөөд парадыг үзэж сонирхсон, зөрж өнгөрсөн хүмүүс алга ташин баяр хүргэж байсан гэнэ. Үүнээс гадна парадын гол онцлог нь Канадын түүхэн дэх анхны ижил хүйстэн мужийн захирагч болох Катлен Вайн оролцсон явдал байв. Мөн Торонто хотын захирагч Жон Тори хүртэл оролцжээ. Парадад оролцсон ижил хүйстнүүд энэ үеэр АНУ-ын Флорида мужийн Орландод болсон шөнийн клубын халдлагын 49 хохирогчийн дурсгалыг хүндэтгэн дуугаа хурааж хүндэтгэл үзүүлсэн байна.

## Үерийн улмаас 40 гаруй хүн гэмтэж бэртлээ

Борооны улирал эхэлсэнтэй холбоотойгоор Энэтхэг, Пакистан зэрэг улсад усархаг бороо хэдэн өдрийн турш үргэлжлэн орсны улмаас олон хүн амиа алдаж байна. Хамгийн сүүлд авсан мэдээллээр үер, хөрсний гулгалтын улмаас хоёр улсад нийтдээ 40 гаруй хүн амиа алдсан гэсэн мэдээлэл байгаа юм. Тухайлбал, Энэтхэгийн хойд этгээдийн Уттараканд мужид өнгөрсөн долоо хоногоос эхлэн усархаг ширүүн бороо үргэлжлэн орсны улмаас үерийн гамшиг нүүрлэж, эдүгээг хүртэл 12 хүн амиа алдаж, 18 хүн ор сураггүй болсонд тооцогдож байна. Мөн тухайн бүсэд хөрсний гулгалт үүсч, 25 хүнтэй холбоо тасарчээ. Харин Пакистаны баруун хойд этгээдийн Хайбер-Пахтунхва мужийн уулархаг хэсэгт орших Читрал тосгонд энэ сарын 1-ний өдрөөс эхлэн усархаг бороо орж, байшин барилга, сүм хийдээс эхлээд машины гараашууд хүртэл усанд автсан байна. Үүний улмаас сүмд мөргөл үйлдэж байсан 30 хүн нас барсан тухай “Франц пресс” агентлаг уламжиллаа. Энэтхэг, Пакистанд борооны улирал эхэлж, усархаг бороо үргэлжлэн орох болсонтой холбоотойгоор тус хоёр оронд цэрэг, цагдаагийн байгууллагууд сураггүй болсон иргэдийг ирэн хайх ажиллагааг эхлүүлсэн байна. Гэвч хоол хүнс, эм тариа, майхан гэх мэт хүмүүнлэгийн тусламж хэрэгтэй байгааг албаныхан учирлаж байгаа ажээ.

## Эрхүүд Ли-76 онгоц сүйрчээ



ОХУ-ын Эрхүү мужид “Ильюшин Ли-76” онгоц сүйрч, нисэх багийнхан бүгд амиа алдсан тухай тус улсын Нислэгийн хороо мэдэгджээ. Осол Эрхүү мужийн Качинский дүүрэгт энэ сарын 1-нд болсон байна. Нисэх онгоц бүрэн сүйрсэний зэрэгцээ тус онгоцонд байсан 10 хүн бүгд амиа алджээ. Тус хороо нисэх онгоцны ослын шалтгааныг тодорхойлохоор ОХУ-ын агаарын тээврийн тухай хуулийн дагуу шалгалтын комисс гарган, энэ сарын 2-ноос ажиллуулж эхэлсэн байна. Сибирьт гарсан томоохон хэмжээний гал түймрийг унтраах ажиллагаанд оролцож байсан “Ильюшин Ли-76” нисэх онгоцны багийнхантай баасан гарагийн өглөө холбоо тасарсан бөгөөд газраар эрэл хийж байсан аврагчид сүйрсэн онгоцыг Эрхүү мужийн Рыбный Уян суурингийн орчмоос олжээ.

## ОХУ-д авсан хоригийг сунгав

Европын Холбооноос ОХУ-д авсан хориг арга хэмжээний хугацааг 2017 оны нэгдүгээр сарын 31 хүртэл буюу зургаан сараар сунгах шийдвэр хэрэгжиж эхэллээ гэж ЕХ-ны албан ёсны сэтгүүлд мэдэгджээ. Хориг арга хэмжээний хугацааг сунгах тухай улс төрийн шийдвэрийг ЕХ зургадугаар сарын 21-нд гаргасан юм. Тус холбооныхон энэ наймдугаар сард ОХУ-тай харилцах харилцаа болоод хориг арга хэмжээтэй холбоотой цаашид арга хэмжээний талаар

Б.ДАВАА

Иракийн нийслэл Багдад хотын төв хэсэгт амиа золиослох террорист ажиллагаа болж, хамгийн сүүлд авсан мэдээллээр амиа алдагсдын тоо 119 болж нэмэгдсэн байна. Уг хэргийн хариуцлагыг хэт даврагч Лалын улс бүлэглэл хүлээхээ мэдэгдсэн аж. Түүнчлэн энэ удаагийн цуврал халдлагаар 180 гаруй хүн гэмтэж бэртжээ. Иракийн Засгийн газар террорист халдлагатай холбоотойгоор аюулгүйн албаны хууль тогтоомжоо шинэчлэх ажлыг эдүгээ эхлүүлэхээр төлөвлөсөн бөгөөд энэ удаагийн хэрэг тус улсын төр засагт томоохон анхааруулга болсон гэдгийг эх сурвалжууд онцолж байлаа.

Халдлага ням гарагийн өглөө Каррада дүүргийн хятад гудамжинд болсон ажээ. Тухайн үед мусайман шашны мөргөлийн сар буюу “Рамадан сар” дуусч байгааг тохиолдуулан эд хэрэглэл худалдан авах иргэдээр тус

...Иракийн Засгийн газрын цэргүүд энэ оны тавдугаар сард тус хотын чиглэлд давшилт эхлүүлж, сар гаруйн дараа Фаллуаж бүрэн чөлөөлсөн билээ...

гудамж дүүрсэн байсан аж. Гэвч гэмтэтгээд халдлага үйлдсэний улмаас гудамж талбай цогцос, цусанд будагдсан байна. Холбогдох эх сурвалжийн мэдээлж буйгаар хохирогчдын бүгдийнх нь цогцосыг

цуглуулах хүртэл хэдэн хоног зарцуулагдаж магадгүй байгаа гэнэ. Хэт даврагч “Лалын улс” бүлэглэлийн мэдээлж буйгаар энэ удаагийн халдлагыг ирак хүнгүйцэтгэсэн бөгөөд тэд Ирак дахь шийтийн урсгалынхныг олноор нь хөнөөх зорилготой байснаа хүлээсэн байна. Энэ явдлаас долоо хоногийн өмнө Иракийн цэргүүд Фаллужа хотыг алан хядагч бүлэглэлээс бүрэн чөлөөлсөн байдаг. Тус улсын Ерөнхий сайд Хайдер аль Абади энэ түүхэн ялалтыг тэмдэглэн Фаллужа хотод хүрэлцэн очиж, телевизээр ард түмэндээ хандан үг хэлсэн бөгөөд тэрбээр “Лалын улс” бүлэглэлд орших зай Иракийн нутаг дэвсгэрт үгүй гэдгийг онцолж, дараагийн удаа Мосул хотыг чөлөөлнө хэмээн амласан. Иракийн нийслэл Багдад хотоос 50 км зайд оршдог Фаллужа хотыг хэт даврагч бүлэглэл 2014 оны нэгдүгээр сард хяналтандаа оруулсан юм. Улмаар Иракийн Засгийн газрын цэргүүд энэ оны тавдугаар сард тус хотын

чиглэлд давшилт эхлүүлж, сар гаруйн дараа Фаллуаж бүрэн чөлөөлсөн билээ. Тэгвэл ийнхүү ялалтаа зарлаж, ялалт байгуулснаа зарлаад байсан Иракийн Ерөнхий сайд Хайдер аль Абади Багдад хотын халдлагатай холбоотойгоор аюулгүйн албаны хууль тогтоомжоо шинэчлэн гэдгээ мэдэгдлээ. Мөн тэрбээр халдлага болсон хятад гудамжинд биечлэн очиж, ноцол байдалтай танишсаны зэрэгцээ гэмт этгээдүүдэд “ялыг хүлээлгэнэ” гэдгээ амлажээ. Одоогоор Иракт гурав хоногийн хугацаатай гашуудал зарлаад байна. Нөгөөтэйгүүр, НҮБ-ын тусгай элч Ян Кубиш халдлагыг “Өмнө нь хэзээ ч гарч байгаагүй бузар үйл ажиллагаа” хэмээн тодорхойлж, эсэргүүцэж буйгаа илэрхийлсэн байна. Мөн Иракийн эрх баригчдаас гэмт этгээдүүдэд шударга ёсыг харуулахыг шаардлаа. Ямартай ч, Ерөнхий сайд Хайдер аль Абади шинэ хууль тогтоомжоо удахгүй мэдээлэх гэнэ.

**М.МАНГО** ТАЛ НУТГИЙН ЦЭХИЙ МЭДЭЭЛЭЛ

07 сарын 04 (Даваа) Улаанбаатар 30°C

Ц.Цэцгийн хуудас 25 минутын өмнө шинэчлэгдсэн.

---

ЭХЛЭЛ    УЛС ТӨР    ЭДИЙН ЗАСАГ    ҮЗЭЛ БОДОЛ    НИЙГЭМ    ДЭГЛЭХИЙ    СПОРТ    ЭНТЕРТАЙНМЭНТ

Сонгууль 2016    Нийтлэл    Ипотехийн эзэл    Ярилцлага    Наадам    Фото мэдээ

---

Түлхүүр үг

ММINFO.мн сайтас

---



М.Алтантуяа:



ХӨӨРХӨН ШУЛАМ

МОНГОЛЫН УРАН САЙХНЫ КИНО

Шулам төрөгөөгүй, амьдралын шаардлагаар бий болдог

# ШУУРХАЙ МЭДЭЭ

## Халуун усанд түлэгдсэн хоёр хүүхэд нас баржээ

Эцэг эхийн хайхрамжгүй байдлаас үүдэн бага насны хүүхдүүд халуун тогоонд хийсэн хоол, цайнд түлэгдэж гэмтэх нь их байна. Өнгөрсөн амралтын өдөр хоёр ч хүүхэд алтан амиа алдсан хэрэг гарчээ. Тухайлбал, Баянгол дүүргийн долдугаар хороо "ГССҮГ хүүхдийн түлэнхийн төвийн тасагт эмчлэгдэж байсан хүүхэд нас барлаа" гэсэн мэдээлэл цагдаагийн байгууллагад ирсэн байна. Тус мэдээллийн дагуу шалгахад, Баян-Өлгий аймагт суух хоёр настай эмэгтэй А нь гэртээ халуун усанд түлэгдэж хэвтэн эмчлүүлж байгаад нас барсан хэргийг шалгаж байгаа гэв. Хүүхэд багачууд гэмтэж, түлэгдэх гол шалтгаан нь эцэг эхийн анхаарал болгоомжгүй байдлаас үүдэлтэй. Хэрэв та бага насны хүүхэдтэй бол халуун тогоо өдөр тутамдаа ашиглаж байгаа бол хүүхэдтэй тавих хараа хяналтаа улам сайжруулахыг цагдаагийн байгууллагаас анхааруулж байна.

## Паурлифтингийн тамирчид дэлхийн аваргаас алтан медаль хүртжээ

Б.НОМИН

Хувцас хэрэглэлгүй паурлифтингийн дэлхийн аварга шалгаруулах тэмцээн зургадугаар сарын 18-26-нд АНУ-ын Техас мужид болсон билээ. Тус тэмцээнд манай орны долоон тамирчин, нэг дасгалжуулагчийн бүрэлдэхүүнтэй оролцсон юм. Тэгвэл манай тамирчид хувцас хэрэглэлгүй паурлифтингийн ДАШТ-нд анх удаа оролцон нэг алт, нэг хүрэл медаль хүртсэн талаар өчигдөр мэдээлэл хийлээ. Тодруулбал, мастер нэг ангилалын 74 кг-ийн жингийн суултын төрөлд С.Энхбат 200 кг-д сууж хүрэл медаль, насанд хүрэгчдийн 93 кг-ийн жингийн шахалтын төрөлд Х.Батгомөр 212.5 кг өргөн алтан медаль хүртсэн байна. Түүнчлэн мастер ангилалд оролцсон манай тамирчид Азийн рекордын дээд амжилтуудыг шинэчлэн тогтоосон аж. Дашрамд дурьдахад, энэ сарын 23-24-нд хувцас хэрэглэлгүй паурлифтингийн УАШТ болох юм байна.

### PHOTO NEWS



70 жилийн түүхтэй Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны тамирчдад очигдөр хүндэтгэл үзүүлээ. "Рио-2016" зуны олимпод тус хорооны 10 тамирчин оролцохоор болсон юм. Тамирчид олимпод хурд хүч, ахаалж салбаа, эр зориг, тэсвэр хатуужлаа сорихоор бэлтгэл сургуулилтаа хангаж, хүчгийн жолоо залахад бэлэн болсон аж.

## Чингис хаанаар согтууруулах ундаа нэрлэхийг эсэргүүцэх хөдөлгөөн байгуулагджээ

Эх түүх, их хаадын сэдэв агуулгаар дагнан үйл ажиллагаа явуулсан 20 шахам жилийн туршлагатай "Хаадын Сан"-гийн Эрдмийн Зөвлөл энэхүү санаачилгыг гаргажээ. Тодруулбал, тус эрдмийн сангийн зөвлөлийн эрдэмтэд Монгол үндэстэн бидний бахархал болсон, мянганы хүмүүн их эзэн Чингис хааны нэрээр архи дарс, шар айраг зэрэг согтууруулах ундааг нэрлүүлэхгүй байх үндэсний хөдөлгөөнийг эхлүүлж байгаа аж. Түүх, соёл, урлагийн бүтээлээс бусад төрлийн бүтээгдэхүүнд их хааны нэрийг ашиглуулахгүй байх тогтоол шийдвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгч болон УИХ-ын төвшинд гаргуулах нь тус зөвлөлийн зорилго гэдгийг онцолж байлаа. Тус эрдмийн зөвлөлөөс "Хятад хэмээх их гүрний дунд цөөнх үндэстэнд орох Өвөр Монголын ахан дүүс маань ийм шийдвэрийг хэдийнээ гаргуулж чадсан байхад их хаадынхаа голомтыг сахиж суугаа,

улс орныхоо эзэн нь болсон монголчууд бид хамтдаа зүтгэвэл ийм шийдвэрийг гаргуулж чадна хэмээн бид итгэж байна. Их хааныхаа нэрээр энэ мэт бүтээгдэхүүнийг нэрлүүлж болохгүй учир шалтгааныг тоочиход үлэмж урт жагсаалт гарах тул шалтгааныг нэг бүрчлэн дурьдахыг хойшлуулав. Монгол хэмээх нэгэн нэрийг ертөнцийн чихнээ дуурсгаж, Монголын үндэсний тулгар төрийг түүчээлэн үүсгэсэн их хааныхаа нэрийг өргөмжлөн өргөж, дуу хоолойгоо нэгтгэхийг ард түмэндээ уриалж байна" хэмээжээ. "Хаадын Сан"-гийн Эрдмийн Зөвлөл болон эрдэмтэн мэргэдийн төлөөлөл ойрын өдрүүдэд Хэвлэлийн бага хурал зарлах аж. Энэ асуудлыг УИХ-ын гишүүн Г.Уянга, ШӨХТГ-ын дарга О.Магнай нар гаргаж, хуулийн төсөл боловсруулж байсан ч хэлэлцэж амжилгүй явсаар УИХ-ын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байгаа юм.

## Энэ сарын 7-нд наадмын тасалбар худалдаанд гарна

Тулгар төрийн 2225, Их Монгол Улсын 810, Ардын хувьсгалын 95 жилийн ойн баяр зэрэг олон тэгш ой давхцсан Үндэсний их баяр наадмын долоо хоногийн дараа болно. Харин наадмын нээлт, хаалт үзэх тасалбарыг энэ сарын 7-наас эхлэн Бөхийн өргөө болон Соёлын төв өргөөний кассуудаар борлуулахаар болжээ. Энэ жилийн наадмын нээлт, бөхийн барилдааны тасалбар суудлаасаа хамаарч 16-24 мянган төгрөгийн үнэтэй байх аж. Мөн жуулчдын тасалбар 25 ам.долларын

үнэтэй худалдаагдах бөгөөд нэг хүнд дөрвөөс илүү тасалбар борлуулахгүй гэнэ. Сонирхуулахад, наадмын бэлтгэл ажил, нээлт хаалтын үйл ажиллагаа зэрэгт зарцуулах нийт зардлын хэмжээг өмнөх жилүүдийн жишгээр баталсан байна. Тодруулбал, баяр наадам зохион байгуулах "Үндэсний хороо" 2014 онд 2.2 тэрбум, 2015 онд 2.9 тэрбум төгрөгөөр наадмын төсвийг баталж байжээ. Энэ жилийнхнийг мөн 2.9 тэрбум төгрөгт багтаахаар болсон байна.

# А.ТУЯА: ИРГЭН ХҮСВЭЛ ЯМАР Ч ХӨРӨНГӨӨ ӨВЛҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ

Н.БАТЗАЯА

*Өв залгамжлах эрх болон хэрхэн өв залгамжлуулах талаар УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга А.Туяагаас тодрууллаа.*

**-Өв залгамжлах эрхийн талаар тайлбарлаж өгөхгүй юу. Ямар тохиолдолд өв залгамжлуулдаг юм бэ?**

Өв залгамжлал нь хууль ёсны болон гэрээслэлээр гэсэн хоёр хэлбэртэй. Хууль ёсны гэдэг нь хуулийн дагуу нас барагчийн нөхөр, эхнэр, хүүхэд, эцэг эх нь эд хөрөнгийг өв залгамжилж авахыг хэлдэг. Харин гэрээслэлээр гэдэг нь тухайн хүн гэрээслэл бичиж, нотариатаар гэрчлүүлсэн нөхцөлд үүсдэг. Өөрөөр хэлбэл, гэрээслэл бичиж үлдээсэн тохиолдолд гэрээслэлд заасан хүн л өв залгамжлах эрхтэй. Ер нь нотариат дээр өвлөх эрхийг тодорхойлж өгдөг. Тэрнээс биш манайд шууд бүртгүүлэх боломжгүй. Нотариатаас өгсөн өвлөх эрхийн гэрчилгээг үндэслэж манайд бүртгэдэг.

**-Өв залгамжлах асуудлаар иргэд танайд хэр ханддаг вэ?**

Монголчууд сүүлийн хэдэн жилийн дотор өвлүүлэх хөрөнгөтэй болж байна. Өвлөх тухайд нэг талаас бидэнд практик

...Үүнээс болж хүмүүсийн хоорондох харилцаанд хүртэл маш том асуудал гарах болсон. Тэгэхээр бодит амьдрал дээр зайлшгүй өвлүүлэх, үүнтэй холбоотой асуудлууд гарч байгаа учраас иргэд муу ёр гэхээс илүү гэр бүл дотроо ярилцан гэрээслэлээр өвөө тодорхойлох хэрэгтэй. Ийм практик шаардлага байгаа нь харагддаг...

байхгүй. Нөгөө талаас муу ёр гэж үздэг уламжлалт сэтгэлгээний асуудал байна л даа. Гэхдээ зайлшгүй өвийн асуудлыг хөндөж, иргэд үүнийг ойлгох хэрэгтэй.

### СЭРЭМЖЛҮҮЛЭГ

## Хачигт халдвараас болгоомжил

Урин дулаан цаг ирж, хүмүүсийн амралт зугаалга эхэлсэн билээ. Үүнтэй зэрэгцээд хачигт халдвар гарах нь ихэсчээ. Тодруулбал, он гарсаар улсын хэмжээнд хачигт халдварын 485 тохиолдол бүртгэгдэж, 181 нь багтагдаад байна. Энэ нь олон жилийн дундажтай харьцуулахад хоёр дахин өссөн үзүүлэлттэй байгаа аж. Хачиг нь арваннэгдүгээр сард ичиж, гуравдугаар сараас хөдөлгөөнд ордог учраас дөрөвдүгээр сараас арвандугаар сар хүртэл идэвхжил нь өндөр байдаг. Тиймээс хөдөө орон нутагт зугаалгаар явахдаа хачигнаас болгоомжлохыг анхаарууллаа.

Иргэд тодорхой хэмжээний хөрөнгөтэй болж байна. Түүнийг дагаад өвийн асуудал нэлээдгүй хөндөгдөх болж. Шүүх, хуулийн байгууллагад өвлөх эрхийн асуудлаар маргаан маш их гардаг. Манай байгууллагад ч мөн адил "Миний өвлөх ёстой хөрөнгийг өөр хүн бүртгүүлчихсэн байна" гэсэн гомдол, маргаан их ирдэг. Тэгэхээр иргэд цаашид өв залгамжлах, өв залгамжлуулах тухай ойлголттой болох байх л даа. Манай оронд хууль эрх зүйн орчин бүрдсэн. Тухайлбал, Иргэний тухай хуулиар өвийн асуудлыг зохицуулж байна. Мөн нотариатын тухай хуулиар нотариатчид өвийг нь тогтоож байгаа. Хамгийн гол нь иргэд өв залгамжлалын талаарх зөв ойлголттой байх хэрэгтэй. Үүний тулд иргэдэд хуулийн сайн сурталчлах шаардлагатай байгаа юм. Ер нь гэрээслэлээр өвлөдөг залгамжлалыг иргэд хэрэгжүүлэх хэрэгтэй. Хүний амьдралд юу ч тохиолдож болно шүү дээ. Хэрвээ би хөрөнгөө тэрэнд өвлүүлнэ гэсэн бодол тухайн иргэнд байгаа бол гэрээслэж үлдээх нь зүйтэй. Гэрээслэл бичиж үлдээгээгүйгээс гэнэт нас барсан тохиолдолд үр хүүхэд болон хамаатнуудын хооронд маш их маргаан гарч байна. Энэ нь үлдэж байгаа хүмүүст маш том асуудал

болдог. Ах дүү нар шийдэж чадахгүйгээсээ болж хоорондоо маргалдаж, мууцалддаг тохиолдлууд их л дээ. Үүнээс болж хүмүүсийн хоорондох харилцаанд хүртэл маш том асуудал гарах болсон. Тэгэхээр бодит амьдрал дээр зайлшгүй өвлүүлэх, үүнтэй холбоотой асуудлууд гарч байгаа учраас иргэд муу ёр гэхээс илүү гэр бүл дотроо ярилцан гэрээслэлээр өвөө тодорхойлох хэрэгтэй. Ийм практик шаардлага байгаа нь харагддаг.

**-Өвлөх хөрөнгөд хэмжээ заадаг уу. тухайлбал, өвлүүлэх хөрөнгө 10 сая төгрөгөөс доошгүй байна гэдэг ч юм уу?**

Хуульд өвлөх хөрөнгөд хэмжээ заадаггүй. Тухайн хүнээс үлдэж байгаа хөрөнгийг хуулийн дагуу гэр бүлийн гишүүдэд өвлүүлдэг. Өвлөх хөрөнгөд юу ч орж болно. Иргэн өөрийн хүссэн хөрөнгөө өвлүүлэх эрхтэй. Тухайлбал, оюуны өмч, үл хөдлөх, хөдлөх хөрөнгө, мал, гэр гэх мэтчилэн юу ч өвлүүлж болно. Хэрвээ гэрээслэл бичиж хэн нэгэнд эд хөрөнгөө өвлүүлж байгаа бол гэрээслэлийн дагуу л хийнэ. Тухайлбал, таван хүүхэдтэй хүн байлаа гэж бодъё. Тэр хүн гэрээслэл бичээд, би отгон хүүдээ эд хөрөнгөө өвлүүлнэ гэвэл тэр дагуу л хийх ёстой. Өмчийн

эзэн юу гэж үзсэн байна түүнээс шалтгаална. Харин гэрээслэл байхгүй бол Иргэний хуулийн дагуу тухайн хүний төрсөн хүүхэд эсвэл эхнэр, нөхөр ижил тэгш өмчийг хувааж авах эрхтэй. Хэрвээ өөрийн төрсөн хүүхэдгүй, эхнэр, нөхөргүй ганц бие хүн байсан бол дараагийн үе буюу ах дүү хамаатан, өвөө эмээ нь өвлөж авна. Гэхдээ тэр хүн гэрээслэл үлдээсэн байвал гэрээслэлийн дагуу л шийдэх ёстой.

**-Гэрээслэлийг өөрийн гараар бичсэн байх ёстой юу?**

Заавал өөрийн гараар бичсэн байна гэсэн зүйл байхгүй. Гол нь гэрээслэлээр өөрийгөө бичсэн гэдгийг баталгаажуулан гарын үсгээ зурж, нотариатаар батлуулсан байх ёстой.

**-Өв залгамжлах эрхийг улсын бүртгэлд бүртгүүлэхэд ямар материал шаардлагатай вэ?**

Хууль залгамжлах эрхийн гэрчилгээ эсвэл гэрээслэл хэрэгтэй. Ингэхдээ эд хөрөнгө оршин байгаа газрын нотариатаар гэрчлүүлж өв залгамжлагч, хамтран өмчлөгчдийн иргэний үнэмлэх, насанд хүрээгүй бол төрсний гэрчилгээний хуулбарыг авч ирэх ёстой. Мөн эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувь хэрэг болдог.

## Хулгайн тэвэрээр зорчихгүй байхыг үр иаллаа

Х.НАРАНЦАЦРАЛ

Засгийн газар 2013 онд Авто тээврийн талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохицуулж, зохион байгуулах үндсэн үүрэгтэйгээр "Авто тээврийн үндэсний төв"-ийг ажиллуулж эхэлсэн билээ. Тэгвэл өчигдөр тээврийн хэрэгслийн осол гэмтэл, зөрчил болон цаг үеийн асуудлаар "Авто тээврийн үндэсний төв"-ийн захирал Д.Батбаатар, ЗЦГ-ын ахлах хошууч Ж.Энхбат нар мэдээлэл хийлээ. Албаныхны мэдээлснээр хот хоорондын авто тээвэрлэлт нь нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг нийт 51 ач ахуй нэгж байгууллагатай гэрээ байгуулан 65 чиглэлд 874 тээврийн хэрэгсэл, 1154 мэргэшсэн жолоочтойгоор тээвэрлэлтийг гүйцэтгэдэг байна. Түүнчлэн авто тээврийн явцад осол гэмтэл гарсан тохиолдолд тус байгууллага харниуцлага хүлээн эрүүл мэндийн даатгал, осол гэмтлийн даатгал зэрэгт бүрэн хамруулдаг аж. Гэтэл дэд бүтэц сайжирсан сүүлийн жилүүдэд осол гэмтэл их гарч, хүний амь нас ихээр хохирч байгааг эдгээр албаны хүмүүс онцолсон юм. Үүний гол шалтгаан нь хурд хэтрүүлсэн, аюулгүй байдал хангаагүй болон 12-оос дээш жилийн насжилттай тээврийн

хэрэгслээр зорчих зэрэг асуудлаас үүсдэг аж. Мөн хулгайн тэвээр маш их газар авч байгаа гэнэ. Хулгайн тэвэрээр зорчиж буй иргэдэд тус байгууллагын зүгээс ямар нэгэн харниуцлага хүлээх боломжгүй байдаг тул ард иргэд зөвшөөрөлтэй авто тээврийн хэрэгслээр зорчиж хэвшихийг "Авто тээврийн үндэсний төв"-ийн захирал Д.Батбаатар уриалсан юм. Мөн ЗЦГ-ын ахлах хошууч Ж. Энхбат "2016 оны эхний зургаан сарын байдлаар Улсын хэмжээнд зам тээврийн ослоор 193 бүртгэгдсэний 138 нь орон нутгийн замд гарч 43 хүн нас барсан. Энэ мэт орон нутгийн замд маш их осол гэмтэл гарч, автомашиныхаа бүрэн бүтэн байдлыг хангаагүйгээс болсон осол их хэмжээгээр гарсаар байгаа. Энэ байдал баяр ёслолын үед улам ихэсдэг учир иргэдийг архи согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ орон нутгийн замд гарахгүй байхыг анхааруулж, хөдөө орон нутгийн 42 постон дээр эргүүл гаргасан байгаа" гэлээ. Дашрамд дуулахад "Авто тээврийн үндэсний төв" "Зам тээврийн яам" хамтран Солонгос улсын дэмжлэгтэйгээр том овринсан, аюулгүй байдлыг бүрэн хангасан 43 автобус оруулж ирэн энэ сарын 20-ноос эхлэн орон нутгийн замд гарахаар бэлэн болсон гэнэ.

## БАЯР ХҮРГЭЖ БАЙНА

Чадаг овогтой Балдансамбуу нь Дэлхийн оюуны өмчийн академийн гавьяат багш цол хүртсэнд баяр хүргэж байна. **Дэлхийн оюуны өмчийн академи ОХУ, Швед, Чех, Швейцарь, Монгол Улс 2016.06.27**

# ЗАВСАРЛАГА

УРАН БҮТЭЭЛЧ



## ХАРИУНЗАЯА

-Зургийн урлаг маш хүнд юм шиг санагддаг. Нэг зураг урт хугацаанд гардаг учраас маш их хөдөлмөрийн үр дүнд хүмүүст хүрдэг. Эрэгтэй, эмэгтэй гэлтгүй уран зургийн урлагт өөрийн гэсэн байр суурийг олж авах хэцүү. Та үүнийг юу гэж боддог вэ?

-Тийм. Уран зураг зураачаас асар их тэвчээр, басхүү хөдөлмөрийг шаарддаг. Нэг зургийг хоёр, гурван өдөр зурах ч тохиолдол байна. Бүр хоёр, гурван жил ч зурдаг. Цаг хугацааны хувьд удаж байж хүмүүст хүрдэг. Тиймээс уран зургийн урлагт өөрийн

санагдсан. Үзэсгэлэнгйхээ талаар ярихгүй юу?

-Өнгөрсөн 15 жилийн хугацаанд дахь хөдөлмөрийн үр шимээ 10 хоногийн турш хүмүүст танилцууллаа. Нэрний хувьд "Passion" буюу хүсэл, тэмүүлэл гэсэн утгатай. Үзэсгэлэнгийн гол зураг маань эмэгтэй хүн өөрийн хүсэл, тэмүүллийнхээ төлөө нийгэмд хандаж орилж байгаа зураг л даа. Өнөөдрийн нийгэмд ихэнх эмэгтэйчүүд муу муухай хүнд ажлыг хийдэг. Эмэгтэй хүн гэдэг утгаараа хүчирхийлэл, хэн нэгэнд дарамтлуулах, өрх толгойлох нь давамгайлах болсон.

дотоод ертөнцийг хүмүүст дэлгэж чадсан.

-Мэргэжлийн уран бүтээлчдээс багагүй урмын үг сонссон гэсэн. Тэд таны зургийг хэрхэн дүгнэж байна вэ?

-Хэд хэдэн уран бүтээлчид "Сайн байна" гэсэн үгнэлгээ өгсөн. Зарим уран бүтээлчид "Монголын уран зургийн пост модерн чиглэлд үнэхээр өнгөний хурц шийдэлтэй, санаагаа чөлөөтэй илэрхийлдэг зураач байхгүй. Дутагдаж байсан" гэж хэлсэн. Би бусад зураачдыг сайн мэдэхгүй л дээ. Гэхдээ зарим зураачид зургийг

Улаанбаатарт:

Маргааш  
Өдөр +32  
Шөнө +18

Нөгөөдөр  
Өдөр +33  
Шөнө +19



Аргын тооллын:  
2016 оны 07-р сарын 04,  
Мянгар гараг

Билгийн тооллын:  
Шинийн 01. 1 цагаан  
лэнгэтэй шар хулгана өдөр

Наран ургах/шингэх:  
06:02 / 21:48

Үс засуулбал:  
Нас ахар болно.

# МИНИЙ ЗУРАГ ХҮМҮҮСИЙН УХАМСАРТ НӨЛӨӨЛЖ БАЙГААГ ХАРАХ ДУРТАЙ

Н.БАТЗАЯА

Пост модерн чиглэлийн чөлөөт уран бүтээлч, зураач Х.Ариунзаяатай цөөн хором ярилцлаа.

-Уран зургийн ертөнцөд шинэ өнгө төрх нэмж гарч ирсэн залуу уран бүтээлч гэж урлаг сонирхогчид өөрийг чинь ярьж байна. Саяхан анхны бие даасан үзэсгэлэнгээ гаргасан шүү дээ. Юуны өмнө манай сонины уншигчдад өөрийгөө танилцуулахгүй юу?

-Намайг Х.Ариунзаяа гэдэг. Баянхонгор аймагт төрсөн. Пост модерн чиглэлээр зурдаг. Чөлөөт уран бүтээлч. Би бага байхаасаа л зураг зурах дуртай хүүхэд байлаа. Тэр хүсэл, сонирхол минь зураг зурахад нөлөөлсөн болов уу гэж боддог юм.

-Пост модерн чиглэлийн уран зургийг нэг удаа хараад ойлгоход хэцүү байдаг. Нэлээн удаан харж, анхаарч байж тухайн зураачийн өгүүлэх гэсэн санааг ойлгодог. Яагаад энэ чиглэлийг сонгож зурах болсон юм бэ. Уран зургийн олон төрөл байгаа шүү дээ?

-Пост модерн чиглэл бол яг л би. Ариунзаяа гэдэг хүн гэсэн үг. Миний зурдаг чиглэл бодит зүйлийг зурахаас татгалзаж, харсан зүйлээ хийсвэрлэж, өөрийн үзэл бодол, өнгө төрхийг зурган дээр илэрхийлж гаргадаг л даа. Өөрөөр хэлбэл, миний зураг бол миний яриа, миний үзэл бодол юм. Тиймээс энэ чиглэлийг сонгож зурах болсон. Нөгөө талаар би багадаа үзэл бодлоо их чөлөөтэй илэрхийлдэг хүүхэд байлаа. Намайг бага байх үед эцэг эхчүүд буруу юм хийв, энэ чинь ийм, тэр чинь тийм гэж их ярьдаг. Тэр үед би томчууд өөрсдөө хийчихээд яагаад

биднийг хийж болохгүй гэдэг юм бэ гэж их боддог байсан юм. Тухайн үед хүүхэд учраас томчуудын урдаас үг хэлж чадахгүй, айдаг. Магадгүй тэр айдас минь миний зурганд илэрч гарсан байх. Тиймээс өөрийн сэтгэлийн гүн дэх бодлыг зурган дээр уудалж, хүмүүсийн ухамсарт нөлөөлдөг чиглэлийг сонгосон. Ер нь томчуудын болохгүй, бүтэхгүй гэсэн зүйлийг болдог юм байна, бүтдэг юм байна шүү гэдгийг зургаараа илэрхийлэхийн тулд зурж эхэлсэн. Би нэг явдлыг одоо болтол тод санадаг. Цэцэрлэгт байхад хүүхдүүдэд гэр зурах даалгавар өгсөн юм. Хүүхдүүд бүгд л цагаан өнгөтэй гэр зурсан. Гэтэл би шар өнгөтэй гэр зурчихсан. Манай багш хэзээ шар гэр байсан юм бэ гэж намайг загнасан. Гэхдээ шар гэр байдаг. Цаг хугацааны өнгөнд гэр хуучирч, илэгдээд шарлагдаж юм билээ. Тэгэхээр би тухайн үед бусдын олж хараагүй зүйлийг хараад зурсан байгаа юм. Энэ зан маань ч гэсэн нөлөөлсөн болов уу.

-Таныг Казахстан улсын зураач Жаннет Абашийн урланд туслах зураачаар ажиллаж байсан гэсэн?

-Тийм. Казахстан улсад 10 гаруй жил амьдарсан. Тэр хугацаанд зураач Жаннет Абашийн урланд туслах зураачаар ажиллаж байсан. Би зурах дуртай учраас миний дотор буцаж байгаа тэр ажлаа л хийсэн юм. Тэр хүнээс олон зүйлийг сурч, мэдэж, туршлага хуримтлуулсан. Казахстанд амьдарч байхдаа хэд хэдэн сэтгүүлд өөрийн зургаа нийтлүүлж байлаа. Тухайлбал, 12 ордны зураг гарсан. Мөн Монголын хүний эрхийн байгууллагаас зарласан уралдаанд "Хайрлахурлаг" гэдэг зураг маань нэгдүгээр байранд шалгарсан. Энэ мэтчилэн олон ажлыг хийж амжууллаа.



өнгө төрхийг олоход хэцүү л дээ. Тэр дундаа чөлөөт уран бүтээлчдийн хувьд хатуухан даваа. Үнэхээр уран зурагт хайртай, дурласан хүмүүс л зургаа зураарч байдаг болов уу гэж боддог юм.

-Чөлөөт уран бүтээлч гэхээр та ямар мэргэжилтэй юм бэ?

-Би гааль, татварын мэргэжилтэй. Одоо мэргэжлээрээ ажилладаггүй. Ер нь өөрийн хүсэл, сонирхолоо сонгосон гэж ойлгож болно.

-Саяхан анхны бие даасан үзэсгэлэнгээ гаргасан. Нэр нь их сонирхолтой

Тиймээс энэ үзэсгэлэнгээрээ эмэгтэйчүүд эрх тэгш сайхан амьдрахыг хүсч байна гэдэг дуу хоолойг харуулахыг зорьсон. Эмэгтэйчүүдийн дуу хоолойг илэрхийлэхийг зорьсон юм. Үзэсгэлэнд дэлгэгдсэн 38 гаруй зурагт энэ агуулга шингэсэн. Мөн хайрыг их зурсан. Одоогийн нийгэмд хайр ямар болсон, хүмүүс хайрыг хэрхэн ойлгож байна вэ гэдгийг зургаараа илэрхийллээ. Ер нь нийгэм дэх эмэгтэйчүүдийн байр суурийг л харуулахыг зорилго. Анхны үзэсгэлэн маш амжилттай болж өндөрлөсөн. Маш их баяртай байна. Өөрийн

минь тэгж үнэлсэн. Миний хувьд мэргэжлийн зураачдаас илүү үзэсгэлэнг минь үзэж, сонирхсон хүмүүсийн урмын үг чухал. Миний "Ээжийн өглөө" гэдэг зураг үзэсгэлэнд орсон. Тэр зургийг минь үзсэн хүмүүс "Эх хүний хайрыг мэдэрдлээ. Ээж минь яг л ийм байсан. Маш эрт босоод л биднийг асардаг байж билээ" гэж хэлээд уйлсан. Зарим нь баярлалаа гэж хэлж байсан. Энэ бол миний хувьд маш том шагнал. Учир нь хүмүүс миний зургаараа дамжуулан илэрхийлэх гэсэн санааг ойлгосон байна шүү дээ. Энэ хамгийн чухал. Өөрөөр хэлбэл, миний зураг хүний ухамсарт нөлөөлж чадаж байна. Ямар ч мэргэжлийн хүнээс илүү миний зургийг ойлгосон энгийн хүний үг илүү болов уу. Гэхдээ мэргэжлийн хүмүүсийн үг чухал байлгүй яах вэ. Ялангуяа анхны бие даасан үзэсгэлэнгээ гаргаж буй шинэ залуу, чөлөөт уран бүтээлчийн хувьд чухал. Тэдний хэлсэн үгнээс цаашид анхаарах ёстой зүйлсийг мэдэж авдаг.

-Зураачид нэг зургийг зурахдаа өөрийн бүх л энергийг шингээж зурдаг. Магадгүй сэтгэлээ шингээж зурсан зураг нь хүмүүст илүү хүрдэг байх?

-Тийм. Би зурж байхдаа зурагтайгаа ярилцдаг. Шивнэж зурдаг. Тухайлбал, чи хүмүүст хайрыг ойлгуулах ёстой шүү. Чи хүмүүст эмэгтэй хүний хүсэл, тэмүүллийг харуулах ёстой гэх мэтчилэн шивнэж, өөрийн санааг хэлж зурдаг. Магадгүй тэгж зурсан зурганд тухайн зураачийн энерги шингэдэг байх л даа. Миний хувьд зурж байгаа зураг болгондоо өөрийн бодол санааг шивнэж зурдаг. Миний зураг хүмүүсийн ухамсарт нөлөөлж байгааг харахад сайхан байдаг. Би түүнийг харах дуртай.



Тухайн өдөр луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын абшиг авах, шинэ гэр ба байр авах, угаал үйлдэх, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улааны үйл, төлөг тавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДУУЛГАХ СОНИН

"Guys" хамтлаг "Хүмүүс ээ" дуугаа клипжүүлээ

"Guys" хамтлагийнхан "Хүмүүс ээ" нэртэй шинэ уран бүтээлийнхээ клипний зураг авалтыг хийжээ. Тус дууны үг аяыг дуучин А.Төгсбаяр хийсэн байна. Мөн дууны клипний зураг авалтад оролцох хүсэлтэй залуусыг Драммын театрын баруун талд "MCS plaza"-гын хойд талбайд урьсан юм. Сонирхуулахад, ирэх жил 20 жилийн ой нь тохнох тус хамтлагийнхан ойдоо зориулан аялан тоглолтуудаа хийж эхэлсэн билээ. Тэд энэ удаад "Best Of Guys" USA Tour 2016" тоглолтынхоо товгыг зарлаад байгаа юм. Энэхүү тоглолт энэ сарын 8-нд Чикогогоос эхлэн Нью-Йорк, Вашингтон Ди Си, Сэйтл, Сан Франциско, Денверт дуусах ажээ.

ТЭНГИС КИНО ТЕАТР

7-р сарын 01-04-ний Үзвэрийн хуваарь

<p>11:00 13:20 17:50 20:20 22:50</p> <p>INDEPENDENCE DAY</p>	<p>10:40 12:50 15:40 19:10 23:00</p> <p>THE PURGE: ELECTION YEAR</p>	<p>10:35 13:00 15:30 18:00 20:30 22:05VIP</p> <p>WARCRAFT</p>	<p>10:30 12:35 14:50 17:00</p> <p>THE DORY</p>	<p>15:00VIP 19:30VIP</p> <p>THE CONJURING 2</p>
<p>12:30VIP 15:00 17:30 20:00 22:30</p> <p>THE MOTHER</p>	<p>17:35VIP 21:20 23:10</p> <p>THE MOTHER</p>	<p>ТУН УДАХГУЙ   2016.7.08</p> <p>THE MOTHER</p>	<p>ТУН УДАХГУЙ   2016.7.29</p> <p>NERVE</p>	<p>ТУН УДАХГУЙ   2016.7.29</p> <p>JASON BOURNE</p>